



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederatiun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарийн хөгжлийн агентлаг



НИЙГМИЙН БОДЛОГО,
ХӨГЖЛИЙН СУДАЛГААНЫ
ХҮРЭЭЛЭН

БИЧИЛ УУРХАЙЧДЫН

“НИЙГЭМ - ЭДИЙН ЗАСАГ, АМЬЖИРГАА”
СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

АМЬДРАЛЫН ТҮҮХЭЭС

Тогтвортой бичил уурхай төсөл

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
олимпийн гудамж 12 “Sky Plaza
business center” 2-р давхар
Ш/х 58, Улаанбаатар 210648
Зип код 14210 Монгол улс

Утас: +976 11 328848
Факс: +976 11 322415



Нинжа

ХАМО

БИЧИЛ
УУРХАЙЧИН

Гарчиг

• Өмнөх үг	2
• Судалгааны хураангуй	4
• Зарим бичил уурхайчдын амьдралын болон бичил уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-уудын түүхүүд	37
- Борнуурын Наранцогт (<i>Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо, Тэргүүн</i>)	38
- Орхонтуулын анхны бичил уурхайчин эмэгтэй (<i>Сэлэнгэ аймаг, Орхонтуул сум, Орхонтуулын хишиг ТББ-ын тэргүүн</i>)	44
- Хулдын анхны бичил уурхайн 13-ын нэг (<i>Дундговь аймаг, Хулд сум</i>)	48
- Шарын голын Оюунтогоо (<i>Дархан-Уул аймаг, Шарын гол сум, “Буянтын хөндийн Шарын гол” ТББ-ын удирдах зөвлөлийн гишүүн</i>)	51
- Бичил уурхайн манлайлагч бүсгүй (<i>Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо, Нарийн бичгийн дарга</i>)	56
- Алтан-Усныхан (<i>Баянхонгор аймаг, Баян-Овоо сум, Алтан усны хөгжил ТББ</i>)	62
- Ажлын амжилт хамт олны итгэлцлээс эхэлдэг (<i>“Хараа нутгийн ажилгүйчүүдийн холбоо” ТББ, Сэлэнгэ аймаг, Баянгол сум</i>)	67
- Байгальд ээлтэй говийн бичил уурхайчид (<i>Дорноговь аймаг, Айраг сум, “Эх орон хамтын хүч” ТББ</i>)	71
- Бичил уурхайн хөгжил - сумын хөгжил (<i>Дундговь аймаг, Хулд сум, “Тахилгат лусын булаг” ТББ</i>)	77
- Зохион байгуулалтаараа тэргүүлэгч байгууллага (<i>Дархан-Уул аймаг, Шарын гол сум, Буянтын хөндий-Шарын гол ТББ</i>)	82
- Цагаан цахирынхан (<i>Баянхонгор аймаг, Баян-Овоо сум, “Хувиараа ашигт малтмал олборлогчдыг дэмжих холбоо” ТББ</i>)	87

Өмнөх үг

2013 онд “Нийгмийн бодлого, хөгжлийн судалгааны хүрээлэн” ТББ-ын судлаачдын баг бичил уурхай бүхий 7 аймгийн 24 сумын 25 ТББ-ын гишүүн 1827 бичил уурхайчдыг хамруулан “Бичил уурхайчдын нийгэм эдийн засаг болон амьжиргаа” судалгааг хийж гүйцэтгэсэн юм.

Бид энэхүү судалгааны тайланг хураангуйлан олны хүртээл болгох, нэгэн үе “нинжа” гэж нэр хоч зүүж хувиараа ашигт малтмал олборлож явсан хүмүүс өөрчлөгдөж хэрхэн өнөөдрийн хариуцлагатай бичил уурхайчин болсон, тэдний амьжиргаа хэрхэн өөрчлөгдөж байгаа талаарх судалгаанд оролцсон хүмүүсийн бодит амьдралын түүх, сургамж, тэд хэрхэн эвлэлдэн нэгдэж өөрсдийн эрх ашгийг хамгаалах ТББ-ыг байгуулж ажиллаж ирсэн туршлагын талаарх мэдээллийг түгээн дэлгэрүүлэх, хуваалцахад дэмжлэг үзүүлэх зорилгоор энэхүү номыг та бүхэнд толилуулж байна.

Энэхүү ном нь бичил уурхайчид зохион байгуулалтад орж, үйл ажиллагаагаа албажуулж тогтвортой ажлын байртай болсноор орлого нь нэмэгдэж, амьжиргаа нь дээшилж байгаагийн зэрэгцээ орон нутгийнхаа эдийн засгийн хөгжилд хэрхэн хувь нэмрээ оруулж байгаа талаар тодорхой мэдээллийг агуулсан болно.

Судалгааны онцлог нь судалгааны байгууллагын мэргэжлийн хүмүүсийн заавар, зөвлөгөө, удирдамжийн дор урьдчилан бэлтгэсэн судалгааны асуулгын дагуу бичил уурхайчдын ТББ-ын гишүүн бичил уурхайчид өөрсдөө судалгааны тоон мэдээллийг цуглуулах ажлыг гардан явуулсанд оршино.

Энэ судалгааны тоон мэдээллийг цуглуулахад бичил уурхайчдын ТББ-ын гишүүдийг татан оролцуулсан нь бичил уурхайчдад ямар нэг болгоомжлол, хардлага сэрдлэггүйгээр судалгааны асуулгыг үнэн зөв бөглөх, судалгаанд шаардлагатай мэдээллийг илэн далангүй өгөх итгэл үнэмшлийг төрүүлж улмаар судалгааны үр дүн амьдралд илүү ойр, бодитой гарахад чухал хувь нэмэр болсон гэж бид үзэж байгаа.

“Бичил уурхайчдын нийгэм эдийн засаг болон амьжиргаа судалгаа”-ны хураангуйг агуулахын зэрэгцээ бичил уурхайчдын бодит амьдралын түүх, сургамжийн талаар хүүрнэсэн энэхүү ном нь Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо, судалгаанд оролцсон бичил уурхайн ТББ-ууд, орон нутгийн удирдлагууд, бодлого боловсруулагчдад бичил уурхайн асуудлаар шийдвэр гаргахад хэрэгцээтэй чухал суурь мэдээлэл болно гэдэгт бид итгэж байна.

Судалгааны тайлангийн хураангуйг боловсруулж, бичил уурхайчдын бодит түүхийг бичиж эмхэтгэн энэхүү номыг гаргахад хамтарч ажилласан “Нийгмийн бодлого, хөгжлийн судалгааны хүрээлэн” ТББ-ын судлаачдын баг, судалгааг явуулахад хамтран ажилласан бичил уурхайчдын байгууллага, орон нутгийн удирдлага, судалгаанд оролцсон болон өөрсдийн түүх, сургамжаасаа харамгүй хуваалцсан бичил уурхайчдад Тогтвортой бичил уурхай төслийн нэрийн өмнөөс гүн талархал илэрхийлж байна.

Пэйшинс Синго

Тогтвортой бичил уурхай төслийн менежер

Бичил уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ТББ-уудын гишүүдийн “нийгэм эдийн засаг болон амьжиргаа” судалгааны үр дүнгийн хураангуй

Танилцуулга

Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон Ашигт малтмалын тухай хууль, Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам зэрэг бодлогын бичиг баримт, хууль тогтоомжид уул уурхай, олборлох салбарын хөгжлийг эрчимжүүлэх, экспортын чиг хандлагатай үйлдвэрлэлийг дэмжих асуудал тусгагдсан. Улсын эдийн засгийн өсөлтөнд бичил уурхайн салбарын оруулах хувь нэмрийг бодитойгоор үнэлэх, албан ёсны баталгаатай, нийгмийн хариуцлагатай бичил уурхайг хөгжүүлэхэд эрхзүйн таатай орчныг бүрдүүлэх шаардлага тулгарч улмаар бичил уурхай эрхлэгчдийн нийгэм-эдийн засаг болон амьжиргаа, байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, бүтэц, зохион байгуулалтын асуудлыг харилцан уялдаатай шийдвэрлэх хэрэгцээ байсаар байна.

Швейцарийн хөгжлийн агентлагаас хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийг албан ёсны зохион байгуулалтад оруулж үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх, албажуулах нь ядуурлыг бууруулах, орон нутгийн иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, орон нутгийн хөгжлийг дэмжих боломж хэмээн үзэж Монгол Улсын Засгийн газарт дэмжлэг үзүүлэхээр шийдвэрлэснээр 2005 оноос Тогтвортой бичил уурхай төслийг (ТБУТ) хэрэгжүүлж эхэлсэн юм. ТБУТ нь Монгол Улсад хариуцлагатай бичил уурхайг төлөвшүүлэхэд холбогдох талуудтай хамтран ажиллаж, бичил уурхай эрхлэгчдийг тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах, эдийн засгийн дэд салбарт үүрэг оролцоотой гишүүн болгохыг зорин ажиллаж байна. 2010 онд Ашигт малтмалын тухай хууль, Газрын тухай хуульд нэмэлт өөрчлөлт орж, Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам батлагдсанаар бичил уурхайн эрх зүйн орчин бүрдсэн.

2013 оны 5-р сарын 2-нд бичил уурхайчид, бичил уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ, нөхөрлөлүүд санаачлан өөрсдийн эрх ашгийг хамгаалах, төр болон бичил уурхайчдыг холбох гүүр болж ажиллах, дуу хоолойг нь бодлого боловсруулагчдад хүргэх зорилгоор “Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо”-г (МБУНДХ) байгуулсан нь бичил уурхайн үйл ажиллагаа нэгдсэн зохион байгуулалтанд орж төлөвшиж байгааг харуулж байна.

ТБУТ-өөс хамтран ажилладаг бичил уурхайчдын ТББ-уудын гишүүдийн нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал болон амьжиргааны түвшин, нэгдсэн зохион байгуулалтад орсноор гарсан өөрчлөлт, үр нөлөөг үнэлэх, судалгааны үр дүнд тулгуурлан бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогч талуудад чиглэсэн /бодлого боловсруулагч, хэрэгжүүлэгч, ТБУТ, Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо, орон нутгийн засаг захиргааны ажилтнууд, бичил уурхайчдын ТББ, нөхөрлөлийн гишүүд/ зөвлөмж, асуудлыг шийдэх гарц, хувилбарыг санал болгох зорилгоор суурь судалгаа явууллаа.

Судалгааны талаар

Суурь судалгааны зорилго нь МБУНДХ, гишүүн ТББ-уудыг чадавхжуулах, судалгааны үр дүн, бусад тоон мэдээллийг бичил уурхайчид авч ашиглах, шинэчлэх, нэгтгэн дүгнэх чадвартай болгоход чиглэсэн бөгөөд санал асуулгын асуултыг бичил уурхайчдын оролцоотойгоор бэлтгэж мэдээллийг бүрдүүлэв. Улмаар судалгааны аргазүй, мэдээлэл цуглуулах оролцооны арга техник, ёс зүйн сургалтыг зохион байгуулж тодорхой мэдэгдэхүүн олгосноор бичил уурхайчид өөрсдөө мэдээлэл цуглуулж судалгаанд оролцлоо.

Судалгааны мэдээлэл нь ТБУТ-ийн зорилго, үйл ажиллагааны уялдаа холбоо, үр дүн болон үр ашигт байдал, үр нөлөөгөө үнэлэх, хянах, харьцуулах, бичил уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллага, нөхөрлөлийн гишүүдийн нийгэм эдийн засгийн суурь мэдээлэл бүхий мэдээллийн санг бүрдүүлэх бөгөөд цаашид МБУНДХ нь мэдээллийн санг жил бүр шинэчлэх боломжтой.

Судалгааны аргачлал

Судалгаанд асуулгын аргыг хэрэглэж тоон мэдээллийг бүрдүүлэн бичил уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 25 ТББ-ын гишүүдийн нийгэм, эдийн засаг болон амьжиргааг тодорхойлсон. Судалгааны үр дүнг боловсруулахдаа олон улсын түвшинд хөгжлийн төсөл хөтөлбөрийн үйл ажиллагаа, үр нөлөө, өөрчлөлтийг үнэлэхэд түгээмэл хэрэглэгддэг Пентагон загварыг (таван хэмжээст загвар) ашиглан дүн шинжилгээ хийж, нэгтгэн дүгнэв. Тодруулбал Пентагон загвараар судалгаанд хамрагдсан бичил уурхайчдын нийгэм эдийн засаг болон амьжиргааг нийгмийн, хүний, биет, байгалийн, санхүүгийн 5 хэмжээст нөөц тус бүрээр үзүүлэлтүүдийг боловсруулж тодорхойлсон болно.

Зураглал 1. Судалгааны агуулгын хүрээг боловсруулахад ашигласан Пентагон загварын 5 хэмжээст нөөц ба түүний үзүүлэлтүүд



Түүврийн төлөвлөгөөг боловсруулахдаа ТБУТ-тай хамтран ажилладаг бичил уурхайчдын нэрсийн жагсаалт, Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоонд бүртгэлтэй гишүүн ТББ-уудын нөхөрлөлийн жагсаалтыг үндэслэн тогтоож, нийт 1827 хүчин төгөлдөр асуулгын хуудсаар мэдээллийг бүрдүүлсэн нь түүврийн эх олонлог хангалттай түвшинд төлөөлөх чадвартай болсон. Судалгааны үр дүнд ТББ, нөхөрлөлийн гишүүдийн суурь мэдээлэл бүхий мэдээллийн сан бүрдэх, цаашид ТБУТ болон Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбооны зорилготой уялдаж байнга харьцуулах, шинэчилж байх тул түүврийн нэгжийн хамрах хүрээг өндөр байлгахыг зорьсон.

Хүснэгт 1. Судалгааны түүврийн хэмжээ, судалгаанд хамрагдсан ТББ-уудаар (N=1827)

ТББ-ын нэр	Нийт
Төв аймаг, Заамар сум (n=208)	
Энхмөнх эргэх холбоо	50
Тосон заамар ундарга	20
Эвсэг туулын гүүр	32
Өгөөмөр эрдэнийн тал	22
Үйлдвэрлэлийн бус аргаар ашигт малтмал олборлогчдын нэгдсэн холбоо	43
Заамар нутгийн хөгжилд бидний оролцоо	41
Баянхонгор аймаг (n=536)	
Алтан усны хөгжил	61
ХАМОДХ	206
Батсайхан сэтгэл	63
Баянбөмбөгөр	60
Байдрагийн хөгжил	146
Говь-Алтай аймаг (n=68)	
Газар шороо ард түмний баялаг	25
Ван тайж	43
Дорноговь аймаг (n=86)	
Эх орон хамтын хүч	69
Хутагтын үр сад	17
Дундговь аймаг (n=166)	
Тахилгат лусын булаг	96
Өлзийтийн хишиг буян	40
Хулд хөгжлийн төлөө хамтдаа	30
Сэлэнгэ аймаг (n=465)	
Дууш мандал хайрхан холбоо	85
Хэрх ноён хайрхан	37
Баатар вангийн хишиг	87
Орхонтуулын хишиг	101
Хараа нутгийн ажилгүйчүүдийн холбоо	84
Баян-Ундарга сан	71
Шарын гол, Дархан (n=298)	
Буянтын хөндий Шарын гол	298
Нийт	1827

Судалгааны дүн

НЭГ. ХҮНИЙ НӨӨЦ

- *Бичил уурхайчдын өрхийн ам бүл, мэргэжил, боловсролын байдал*

Судалгаанд хамрагдсан бичил уурхайчдын өрхийн хүн ам зүйн шинж байдлыг тодорхойлох үндсэн үзүүлэлт болох ам бүлийн байдлыг авч үзэхэд, хамгийн олон нь 12 ам бүлтэй байсан бол судалгаанд хамрагдсан нийт өрхийн ам бүлийн тооны дундаж 4.21 буюу 4-5 ам бүлтэй байлаа. Бичил уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 25 ТББ-ын гишүүдийн өрхийн ам бүлийн тоог хүн амын тооллогын үндсэн ангиллаар авч үзвэл, 2 өрх тутмын нэг нь буюу 56.5 хувь нь 2-5 ам бүлтэй, 4 хувь нь нэг ам бүлтэй буюу ганц бие, 39.6 хувь нь харьцангуй олон буюу 6-аас дээш ам бүлтэй байна. Судалгаанд хамрагдсан бичил уурхайчдын 70.9 хувь нь эрэгтэй, нийт бичил уурхайчдын дундаж нас ± 37.14 байгаагаас эрэгтэй дундаж нас ± 36.50 , эмэгтэй дундаж нас ± 38.86 байна.

Судалгаанд хамрагдсан бичил уурхайчид дунджаар 2 хүүхэдтэй байсан бөгөөд 90 гаруй хувь нь сургууль завсардсан буюу бичил уурхай эрхэлж байгаа хүүхэд байхгүй гэж хариулсан бол 4 орчим хувь нь сургууль завсардсан хүүхэдтэй, 5 орчим хувь нь сургуулийн насны ажил эрхэлдэг хүүхэдтэй гэж тус тус хариулсан байна. Энэ нь бичил уурхайчин өрхийн сургууль завсардсан хүүхдийг сургуульд хамруулах, уул уурхайд хүнд хөдөлмөр эрхэлж эрх нь зөрчигдөж буй хүүхдийг хөдөлмөр эрхлэлтээс хөндийрүүлэх, зогсоох асуудалд төрийн захиргааны болон орон нутгийн засаг захиргааны байгууллагууд, бичил уурхайчдын байгууллага, бичил уурхайчид онцгой анхаарал хандуулах шаардлагатай байгааг харуулж байна.

Судалгаанд хамрагдсан бичил уурхайчдын 43 хувь нь бүрэн бус дунд боловсролтой байгаа нь хамгийн өндөр хувийг эзэлж байна. Тодруулбал, судалгаанд хамрагдсан бичил уурхайчдын 12.1 хувь нь ямар нэгэн мэргэжил эзэмшсэн бол (мэргэжлийн/техникийн ба дээд боловсрол) 3 хүн тутмын нэг нь бүрэн дунд, 9 хувь нь бага боловсролтой, 1 хувь нь ямар ч боловсролгүй байна.

Бичил уурхайчдын эзэмшсэн мэргэжлийн байдлыг авч үзвэл 6 орчим хувь нь багш, хуульч, эдийн засагч, ня-бо, агрономич, инженер, малын эмч, менежер, хүний эмч мэргэжилтэй байв. Судалгаанд хамрагдсан 2 бичил уурхайчны нэг нь ямар нэгэн мэргэжил эзэмшээгүй байна. Ажил мэргэжлийн хувьд жолооч, хүнд машин механизмын оператор, малчин, механикч, тракторч, тогооч, барилгачин, гагнуурчны мэргэжилтэй бичил уурхайчид зонхилж байгаа юм.

Суурь судалгаанд хамрагдсан бичил уурхайчдын өрхийн насанд хүрсэн хөдөлмөрийн чадвартай 2-3 хүний 1-2 нь ямар нэгэн орлоготой ажил эрхэлж байгаа нь эдийн засгийн идэвх харьцангуй эерэг үзүүлэлттэй байгааг харуулж байна. Судалгаанд оролцсон хөдөлмөрийн чадвартай 2-3 хүн тутмын 2 нь бичил уурхайгаар ашигт малтмал олборлодог гэж хариулсан нь бичил уурхайчдын орлогын гол эх үүсвэр болсон бичил уурхайн салбарт байнга ажиллаж буй хүн амын тоо өндөр байгааг харуулж байна. Бичил уурхайн эрх зүйн орчин бүрдсэнээр бичил уурхайн салбар нь баталгаатай ажлын байрыг бий болгож эзэмшсэн мэдлэг, боловсрол, мэргэжлээс шалтгаалахгүйгээр бичил уурхайчид төдийгүй тэдний гэр бүлийн хөдөлмөрийн насны гишүүдийн ажил эрхлэлтийн түвшин өндөр байгаад нөлөөлжээ.

Судалгаанд хамрагдсан 328 бичил уурхайчин бичил уурхайгаас олсон орлогоороо нийт 536 оюутан хүүхдийн сургалтын төлбөрийг төлж байгаа бөгөөд оюутнуудын 22.3 хувь нь эрэгтэй, 17.1 хувь нь эмэгтэй байна. Судалгаанд хамрагдсан 35 бичил уурхайчин манай өрх 2 эрэгтэй оюутан сургадаг, судалгаанд хамрагдсан 73 бичил уурхайчин манай өрх 2 эмэгтэй оюутан сургадаг гэж хариулснаас харахад охин хүүхдээ сургадаг гэж хариулсан нь даруй 2 дахин өндөр байна.

Хүснэгт 2. Бичил уурхайчин өрхийн оюутны тоо

Оюутан эрэгтэй хүүхдийн тоо		
Байхгүй	1603	87.7
1	189	10.3
2	35	12.0
Оюутан эмэгтэй хүүхдийн тоо		
Байхгүй	1515	82.9
1	239	13.1
2	73	4
Нийт	1827	100.0

Бичил уурхайн салбарын ажлын байрны онцлогоос шалтгаалж эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн оролцоо ялгаатай, тодруулбал бичил уурхайн салбарт эрэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин өндөр байхад үр хүүхэддээ мэргэжил боловсрол эзэмшүүлэхдээ охиддоо илүү анхаарал тавьж дээд сургуульд сургах хандлага давамгайлж байна.

- *Бичил уурхайчдын эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд хамрагдсан байдал*

Бичил уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж, зохион байгуулалтад орсон ТББ, нөхөрлөлийн гишүүдийн эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд хамрагдалтын түвшин жилээс жилд нэмэгдэж байгааг судалгаанд хамрагдсан бичил уурхайчдын өгсөн мэдээлэл харуулж байна. Суурь судалгаанд хамрагдсан бичил уурхайчдын 62.1 хувь нь эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ тогтмол төлдөг бол даатгалд хамрагдаагүй бичил уурхайчид ЭМД-д хамрагдана гэсэн байр суурьтай байлаа.

Хүснэгт 3. Судалгаанд хамрагдсан бичил уурхай эрхлэгчдийн эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд хамрагдсан тоон мэдээлэл (25 ТББ-аар)

ТББ-ын нэр	Эрүүл мэндийн даатгал	Нийгмийн даатгал	Нийт судалгаанд оролцогчийн тоо
Энхмөнх эргэх холбоо	39	21	50
Тосон Заамар ундарга	18	16	20
Эвсэг Туулын гүүр	26	21	32
Өгөөмөр эрдэнийн тал	22	0	22
Үйлдвэрлэлийн бус аргаар ашигт малтмал олборлогчдын нэгдсэн холбоо	40	31	43
Заамар нутгийн хөгжилд бидний оролцоо	41	37	41
Алтан усны хөгжил	25	3	61
ХАМОДХ	127	39	206
Батсайхан сэтгэл	62	33	63
Баянбөмбөгөр	32	41	60
Байдрагийн хөгжил	70	20	146
Газар шороо ард түмний баялаг	21	5	25
Эх орон хамтын хүч	42	37	69
Ван тайж	30	10	43
Тахилгат лусын булаг	76	71	96
Өлзийтийн хишиг буян	36	33	40
Дууш мандал хайрхан холбоо	47	42	85
Хэрх ноён хайрхан	15	3	37
Баатар вангийн хишиг	42	27	87
Орхонтуулын хишиг	35	28	101
Хараа нутгийн ажилгүйчүүдийн холбоо	32	14	84
Баян-Ундарга сан	10	3	71
Буянтын хөндий Шарын гол	201	9	298
Хутагтын үр сад	16	15	17
Хулд хөгжлийн төлөө хамтдаа	30	30	30
Нийт	1135	589	1827

Бичил уурхайн эрх зүйн орчин бүрдсэнээр бичил уурхайчид нөхөрлөлийн зохион байгуулалтад орж, улмаар эвлэлдэн нэгдэж ТББ байгуулж, үйл ажиллагаагаа албажуулж, албан ёсны хүлээн зөвшөөрөгдсөн ажлын байртай болсноор эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд хамрагдаж, шимтгэлээ төлдөг болж, Үндсэн хуулиар баталгаажсан эрүүл мэндээ хамгаалуулах, эрүүл мэндийн болоод нийгмийн халамжийн үйлчилгээ авах эрхээ эдлэх боломжтой болжээ. Судалгаанд хамрагдсан нийт 1827 бичил уурхайчны 589 нь (32.2%) нийгмийн даатгалд, 1135 нь (62.1%) эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байна. Нийгмийн даатгалд хамрагдалтын хувийг эрүүл мэндийн даатгалд хамрагдсан үзүүлэлттэй харьцуулж үзэхэд 2 дахин бага байгаа хэдий ч цаашид даатгуулна гэсэн чиг хандлагатай байгаа нь даатгалын ач холбогдлыг ойлгосныг харуулж байна.

ХОЁР. САНХҮҮГИЙН НӨӨЦ

- *Бичил уурхайчдын өрхийн орлого, амьжиргааны эх үүсвэр*

Бичил уурхайчид бичил уурхайн үйл ажиллагаа, цалинтай ажил, тэтгэвэр/тэтгэмж, мал аж ахуй, жижиг дунд үйлдвэр, өрхийн бизнес зэргээс орлогоо бүрдүүлдэг байна. Эдгээрээс өрхийн орлогыг бүрдүүлж байгаа эх үүсвэрийн хувь хэмжээг эрэмбэлж үзвэл, нэгдүгээрт бичил уурхайгаас олдог орлого, хоёрдугаарт хүүхдийн мөнгө, гуравдугаарт цалин хөлс тус тус орж байна. Судалгаанд хамрагдсан бичил уурхайчдын дийлэнх нь буюу 64.2 хувь нь бичил уурхайгаас олдог орлого өрхийн орлогод томоохон байр суурь эзэлдэг гэж хариулсан ба энэ нь хариултын бусад сонголтоос даруй 20 дахин өндөр үзүүлэлт болж байна.

Хүснэгт 4. Бичил уурхайн үйл ажиллагаа явуулж буй 25 ТББ-ын гишүүдийн орлогын эх үүсвэрийг бичил уурхайн зохион байгуулалтад орохоос өмнөх орлогын эх үүсвэртэй харьцуулсан байдал (хувиар)

Орлогын эх үүсвэр	Бичил уурхайн зохион байгуулалтад орохоос өмнөх орлогын эх үүсвэр	Бичил уурхайн зохион байгуулалтад орсны дараах орлогын эх үүсвэр
Бичил уурхай	58.7	64.2
Цалинтай ажил	15.9	14.5
Тэтгэвэр тэтгэмж	9.4	9.0
Хүүхдийн мөнгө	45.1	40.5
Жижиг дунд үйлдвэр, өрхийн бизнес	5.0	5.5
Мал аж ахуй	11.8	9.3
Газар тариалан, төмс хүнсний ногоо	3.3	2.7
Дэлгүүр	2.1	2.7
Цайны газар	0.9	1.0
Дугуй засварын газар	0.7	0.3

Одоогийн орлогын эх үүсвэрийг бичил уурхайн зохион байгуулалтад орохоос өмнөх үеийн тоон мэдээлэлтэй харьцуулахад бичил уурхайчдын орлогын эх үүсвэрүүдийн эзлэх хувийн жин ерөнхийдөө өссөн хандлага ажиглагдаж байна. Жишээ нь судалгааны дүнгээр, бичил уурхай эрхэлж олох орлого 5 орчим, өрхийн жижиг дунд үйлдвэр, өрхийн бизнес эрхэлснээс олох орлого 0.5 орчим, дэлгүүр ажиллуулснаас олох орлого 0.5 орчим, цайны газар ажиллуулснаас олох орлого 0.1 орчим хувиар өссөн дүнтэй байна. Энэ нь бичил уурхайгаас олсон орлогоороо хуримтлал үүсгэж, улмаар бичил уурхай эрхлэхийн зэрэгцээ өрхийн амьжиргаанд нэмэр болохуйц дэлгүүр, цайны газар гэх мэтчилэн өрхийн бизнес эрхлэх боломжийг давхар бүрдүүлж байгааг харуулж байна.

- Бичил уурхайчдын бичил уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулснаар олсон дундаж орлого

Бичил уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 25 ТББ-ын гишүүдийн 85.6 хувь нь алт, 13.1 хувь нь жонш, үлдсэн хувь нь өнгөт чулуу олборлож орлого олж байна. Бичил уурхай эрхлэгчдийн орлогын гол эх үүсвэрийг бичил уурхайгаас олох орлого бүрдүүлдэг ч зарим бичил уурхайчид бичил уурхайгаар олж буй орлогын мэдээллээ өгөхөөс татгалзах, орлогоо нарийвчилан тодорхойлж чадахгүй байх зэрэг шалтгааны улмаас орлогын хэмжээгээ бууруулж мэдээлж байлаа. Бичил уурхайчид өдөрт хамгийн багадаа 20.000-30.000 төгрөг, дээд тал нь 50.000-100.000 төгрөг олох үе байхад огт орлого олохгүй өдөр ч байдаг, орлогоо тодорхойлж хэлж мэдэхгүй байна гэсэн хариултуудыг өгчээ. Бичил уурхайчдын өгсөн орлогын мэдээлэлд тулгуурлан тооцоход тэдний сарын орлого 150.000-2.500.000 төгрөг, сарын дундаж орлого 352.045 төгрөг байна.



Бичил уурхайчин нэг өрх дунджаар 4.21 ам бүлтэй байсан ба өрхийн сарын дундаж орлого 390.929 төгрөг байгаа нь Үндэсний статистикийн хорооноос гаргасан 2012 оны нэг өрхийн сарын дундаж орлогоос бага байна. 2012 оны байдлаар ҮСХ-ны мэдээгээр хөдөөгийн нэг өрхийн мөнгөн орлого 494.738 төгрөг байна.¹

¹ Монгол Улсын статистикийн эмхэтгэл, 2012 он (хуудас 302)

Суурь судалгаанд хамрагдсан нийт бичил уурхайчдын 372 нь буюу 20 орчим хувь нь мал аж ахуйгаас өрхийн амьжиргааны бас нэг эх үүсвэрээ хангаж байгаа нь бичил уурхайчдын 63.4 хувь нь үхэр, 60 хувь нь хонь, 63.7 хувь нь ямаа, 36 хувь нь адуу, 4 хувь нь тэмээтэй гэж хариулснаас харагдаж байна. Бичил уурхайчид мал аж ахуйг бизнесийн зорилгоор бус өрхийн мах, сүүний хэрэгцээгээ хангах амьжиргааны эх үүсвэр болгон эрхэлж байна.

Бичил уурхайчид зохион байгуулалтад орсноор өрхийн эдийн засаг болон амьжиргааны түвшинд гарсан өөрчлөлт

Бичил уурхайчид зохион байгуулалтад орж албажсанаар өрхийн орлого нэмэгдсэн гэж судалгаанд хамрагдсан бичил уурхайчдын 42 орчим хувь үзсэн нь бусад хариултуудын дотор хамгийн өндөр хувийг эзэлж байгаа юм. Бичил уурхайчдын орлого нэмэгдэж, хоол хүнс, өдөр тутмын хэрэгцээг хангахад зарцуулсан зардлаас гадна өрхийн амьжиргааг сайжруулахад чиглэсэн зардлын эзлэх хувь хэмжээ нэмэгдсэн нь судалгааны баримтаас ажиглагдаж байна.

Хүснэгт 5. Зохион байгуулалтанд орж албажсанаар бичил уурхайчин өрхийн эдийн засаг болон амьжиргаанд гарсан өөрчлөлтүүд

Сонгосон үзүүлэлтээр	Тоо	Хувь
Суудлын машинтай болсон	433	23.7
Ачааны машинтай болсон	158	8.6
Мотоциклтой болсон	336	18.4
Шинээр байшин барьсан	106	5.8
Нар, салхины цахилгаан үүсгүүртэй болсон	118	6.5
Цахилгаан мотортой болсон	351	19.2
Хөргөгчтэй болсон	545	29.8
Угаалгын машинтай болсон	561	30.7
Телевизортой болсон	615	33.7
DVD, CD хөгжимтэй болсон	291	15.9
Мал авсан	159	8.7
Ажлын тоног төхөөрөмж шинээр авсан	270	14.8
Гэртэй болсон	209	11.4
Гэрийн дээвэр, туурга, бүрээс авсан	164	9.0
Гэр ахуйн хэрэгцээт зүйл авсан (орны бүтээлэг, гудас г.м)	264	14.4
Хашаа, байшингаа засч сайжруулсан	263	14.4
Мөнгөн хадгаламжтай болсон, хадгаламжийн хэмжээ нэмэгдсэн	166	9.1
Хувийн бизнестэй болсон (дэлгүүр, цайны газар)	87	4.8
Оюутан хүүхдийн сургалтын төлбөрийг төлж байна	328	18.0
Хууль ёсоор бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэх ажлын байртай болсон	578	31.6
Өрхийн орлого нэмэгдсэн	757	41.4
Өрхийн амьжиргааны түвшин сайжирсан	541	29.6
Өрөө төлж дуусгасан (банк, хувь хүнд)	237	13.0
Эрүүл мэндийн даатгалд хамрагдсанаар эрүүл мэндийн тусламж авдаг болсон	379	20.7
Цагаан сар, наадам, шинэ жилийн баярыг ТББ, нөхөрлөл тэмдэглэдэг болсон	544	29.8
Сумын дэлгүүрийн бараа таваарын хангамж, иргэдийн худалдан авалт нэмэгдсэн	462	25.3

- **Сүүлийн 2-3 жилийн доторх орлогын энэхүү өсөлтийн гол шалтгаан нь хувиараа ашигт малтмал эрхлэх хэлбэрээс хөөгдөж туугдахгүйгээр тайван нөхцөлд зохион байгуулалттайгаар бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэх болсон нь голлон нөлөөлжээ.**

Тухайлбал, мөнгөн хадгаламжтай бичил уурхайчин өрхүүдийн 60 шахам хувийнх нь мөнгөн хадгаламжийн хэмжээ өссөн дүнтэй байна.

Бичил уурхайчид өрхийнхөө өдөр тутмын хэрэгцээг хангахаас гадна ажлын тоног төхөөрөмж авах, машин унаа авах, мөнгөн хадгаламжтай болох, дэлгүүр, цайны газартай болсон гэсэн хариултуудыг өгчээ. Эндээс харвал бичил уурхайн үйл ажиллагаа зохион байгуулалтад шилжсэнээр бичил уурхайчдын ашиг орлого нэмэгдээд зогсохгүй өрхийнхөө тогтвортой амьжиргааг хангахад чиглэсэн жижиг бизнес эрхлэх бололцоотой болсон нь бичил уурхайчдын ТББ-ын гишүүдийн эдийн засаг болон амьжиргаанд гарсан томоохон өөрчлөлт болжээ. Судалгаанд оролцсон бичил уурхайчдын 742 (40%) нь орон гэр, хашаа байшин шинээр авах буюу орон байрны нөхцлөө сайжруулж, 927 (49.2%) нь машин, мотоцикл худалдан авснаас гадна нийт 2481 ширхэг гэр ахуйн цахилгаан хэрэгсэл худалдаж авсан нь бичил уурхайчин өрхийн амьжиргаанд дорвитой эерэг өөрчлөлт гарч, амьдралын чанар дээшилснийг харуулж байна.

- **Бичил уурхайн ТББ, нөхөрлөлүүд дундын сантай болж, хуримтлал үүсгэж байгаа нь эдийн засгийн хувьд чадавхжих эхлэл тавигдаж байгааг харуулж буй нэг үзүүлэлт мөн.**

Судалгаанд хамрагдсан бичил уурхайн ТББ, нөхөрлөлийн гишүүд сар бүр дундын мөнгөн хуримтлалын санд 20.000-50.000 төгрөг хуримтлуулж байна. Дундын сангийн мөнгөн орлогын хэмжээг ТББ, нөхөрлөлийн гишүүдийн мэдээлэлд үндэслэн тооцоход судалгаанд хамрагдсан 25 ТББ 2012 онд 60.000.000-80.000.000 төгрөг, 2013 онд 100.000.000-120.000.000 төгрөг тус тус хуримтлуулсан байх боломжтой гэсэн дүр зураг гарч байгаа нь бичил уурхайн үйл ажиллагаа албажиж, зохион байгуулалтад орсноор бичил уурхайчдын байгууллага санхүүгийн хувьд чадавхжиж, үйл

ажиллагаа нь тогтворжиж байгааг харуулж байна. Харин тогтвортой бус үйл ажиллагаатай ТББ, нөхөрлөлүүд сар бүр хуримтлал бий болгож чадаагүйгээс бичил уурхайн нөхөн сэргээлт, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаагаа сайжруулах болон нийгэмд чиглэсэн үйл ажиллагаа хэрэгжүүлж чадахгүй байгааг судалгаанд хамрагдсан ТББ-ын зарим удирдлага тэмдэглэлээ.

- Судалгаанд хамрагдсан **бичил уурхайн ТББ, нөхөрлөлүүд орон нутгийн хөгжилд зориулж 2012 онд 10 мянгаас 15 сая төгрөг, 2013 онд 10 мянгаас 50 сая төгрөг хандивласан байна. Ийнхүү бичил уурхайчдын орон нутгийн хөгжилд оруулсан хандив, хөрөнгө оруулалт нэг жилийн хугацаанд 5 дахин өссөн үзүүлэлт** нь бичил уурхайчид нийгмийн хариуцлагаа ухамсарлаж, орон нутгийн хөгжилд тодорхой хувь нэмэр оруулж байгааг харуулж байна.

Бичил уурхайчид орон нутгийг хөгжүүлэхэд чиглэсэн бүтээн байгуулалтад оролцох, мөнгөн хандив өгөх, тэмдэглэлт ой, соёл, спортын арга хэмжээ, байгаль орчныг хамгаалах компанит ажил зохион байгуулах зэрэг үйл ажиллагааг санаачлан хийж байгаа нь бичил уурхайчид орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулдаг, нийгмийн идэвхтэй гишүүд болж төлөвшсөнийг илтгэж байна.

Хүснэгт 6. Судалгаанд хамрагдсан бичил уурхайчдын ТББ-уудын орон нутгийн хөгжилд оруулсан хувь нэмэр

Байгаль орчин	• Мод бургас, суулгац тарьсан. • Байгаль орчны цэвэрлэгээнд техник машин гаргаж тусалсан • Голын дагуух хогийг цэвэрлэсэн • Сумын төвийн хогийг цэвэрлэж зайлуулсан • Зүлэгжүүлэлт хийсэн
Сумын баяр, наадам	• Ойн баяр наадамд хонь мал бэлэглэсэн • Морины бай шагналыг даасан • Унаач хүүхдийн шагналыг даасан
Сумын барилгын өнгө үзэмж, тохижилт	• Сумын захиргааны байранд засвар хийсэн • Сумын захиргааны байранд тавилга авч өгсөн • Өнгөт чулуун багана босгосон • Сумын захиргаанд тоног төхөөрөмж, компьютер авч өгсөн • Усан оргилуур барьсан • Цэцэрлэгт хүрээлэнг засч тохижуулсан
Сумын ахуй үйлчилгээний ажил	• Халуун ус барьж ашиглалтанд оруулсан
Орон нутгийн барилгын ажил	• Гүүр барих болон зам засах ажилд оролцсон • Далан сэргээж зассан • Үер усны шуудуй ухсан • Сумын наадмын талбайг зассан
Олон нийтийн ажил	• Гар бөмбөгийн тэмцээн зохион байгуулсан • Уралдаан тэмцээнд оролцсон • Уул уурхайн талаар ойлголт өгөх сургалт үнэ төлбөргүй зохион байгуулсан
Орон нутгийн иргэдэд зориулсан тусламж	• Малчдад хандив өгсөн • Малчдад тусламж үзүүлсэн

ГУРАВ. БАЙГАЛИЙН НӨӨЦ

Судалгаанд хамрагдсан бичил уурхайн үйл ажиллагаа явуулдаг 25 ТББ-аас 16 нь албан ёсны зөвшөөрөлтэй 145.3 га талбай бүхий олборлолтын газартай, харин Өлзийтийн хишиг буян (Дундговь, Өлзийт сум), Энхмөнх эргэх холбоо (Төв, Заамар сум), Үйлдвэрлэлийн бус аргаар ашигт малтмал олборлогчдын нэгдсэн холбоо (Төв, Заамар сум), Заамар нутгийн хөгжилд бидний оролцоо (Төв, Заамар сум), Хэрх ноён хайрхан холбоо (Сэлэнгэ, Мандал сум), Баатар вангийн хишиг (Сэлэнгэ, Мандал сум), Орхонтуулын хишиг (Сэлэнгэ, Орхонтуул сум), Хараа нутгийн ажилгүйчүүдийн холбоо (Сэлэнгэ, Баянгол сум), Баян-Ундарга сан (Сэлэнгэ, Ерөө сум) зэрэг нийт 9 ТББ зөвшөөрөгдсөн ашиглалтын талбай байхгүй байгааг судалгааны дүн харуулж байна.

Хүснэгт 7. Судалгаанд хамрагдсан бичил уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 25 ТББ-ын бичил уурхайн зориулалтаар ашиглаж буй талбайн хэмжээ

№	ТББ-ын нэр	Байршил	Олборлолт явуулдаг газрын нэр	Зөвшөөрсөн газрын хэмжээ (га)
1	Алтан усны хөгжил	Баянхонгор, Баян-Овоо	Алтан ус	1.5
2	ХАМОДХ	Баянхонгор, Баян-Овоо	Цагаан цахир	30
3	Батсайхансэтгэл	Баянхонгор, Галуут	Өвөр бараан хад	1
4	Баянбөмбөгөр	Баянхонгор, Бөмбөгөр	Буйлсан, Ширхэн	5
5	Байдрагийн хөгжил	Баянхонгор, Жаргалант	Мандал бөөрөг	13
6	Газар шороо ард түмний баялаг	Говь-Алтай, Есөнбулаг	Өндөр дэнж	1.5
7	Ван тайж	Говь-Алтай, Есөнбулаг	Ялаат	0.8
8	Эх орон хамтын хүч	Дорноговь, Айраг	Алтад, Цахиурт	1
9	Хутагтын үр сад	Дорноговь, Айраг	Арван ес, Бороодой, Тагт	1

10	Тахилгат лусын булаг	Дундговь, Хулд	Түймэрт цагаан, Тахилгат цагаан	50
11	Хулд хөгжлийн төлөө хамтдаа	Дундговь, Хулд	Түймэрт цагаан	50
12	Өлзийтийн хишиг буян	Дундговь, Өлзийт	Ембүү дэрсэн ус	-
13	Энхмөнх эргэх холбоо	Төв, Заамар	Баянголын ам	-
14	Тосон ундрага Заамар	Төв, Заамар	Ар наймган	0.5
15	Эвсэг Туулын гүүр	Төв, Заамар	Туулын гүүрийн ойролцоо	0.5
16	Өгөөмөр Эрдэнийн тал	Төв, Заамар	Алтан дорнод	5
17	Үйлдвэрлэлийн бус аргаар ашигт малтмал олборлогчдын нэгдсэн холбоо	Төв, Заамар	Алтан дорнод, Цагаан чулуут	-
18	Заамар нутгийн хөгжилд бидний оролцоо	Төв, Заамар	Цагаан чулуут	-
19	Дууш мандал хайрхан холбоо	Сэлэнгэ, Мандал	Ноёд	12.2
20	Хэрх ноён хайрхан	Сэлэнгэ, Мандал	Билүүт, Гэмлүүт	-
21	Баатар вангийн хишиг	Сэлэнгэ, Мандал, Түнхэл	Буданч бор толгой	-
22	Орхонтуулын хишиг	Сэлэнгэ, Орхонтуул	Тоорой мод	-
23	Хараа нутгийн ажилгүйчүүдийн холбоо	Сэлэнгэ, Баруунхараа	Шар нарст	-
24	Баян-Ундрага сан	Сэлэнгэ, Ерөө	Харгана, Могойт, Өлөнт	-
25	Буянтын хөндий Шарын гол	Дархан-Уул, Шарын гол	Буянтын хөндий	2
Нийт				145.3

Судалгаанд хамрагдсан бичил уурхайн 25 ТББ-ын 85.6 хувь нь алт, 13.1 хувь нь жонш, 1.3 хувь нь өнгөт чулуу олборлож, нэг нөхөрлөл сард дунджаар 50-100 грамм алт, 100-250 тн жонш, 4 тн өнгөт чулуу олборлодог байна.



Судалгаанд хамрагдсан 25 ТББ 2012 онд 15 га, 2013 онд 32.6 га талбайд тус тус нөхөн сэргээлт хийсэн нь өмнөх жилтэй харьцуулахад 2 дахин өсчээ.

25 ТББ-ын 11 нь сүүлийн 2 жилд 28.8 га талбайд техникийн нөхөн сэргээлт, 16 га талбайд биологийн нөхөн сэргээлт, 1.5 га талбайд суулгац мод тарьсан байна.

Хүснэгт 8. Судалгаанд хамрагдсан бичил уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй зарим ТББ-ын нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа (га-гаар)

№	ТББ-ын нэр	2012			2013	
		Техникийн нөхөн сэргээлт	Биологийн нөхөн сэргээлт	Суулгац, мод тарих	Техникийн нөхөн сэргээлт	Биологийн нөхөн сэргээлт
1	Алтан усны хөгжил Баянхонгор, Баян-Овоо	2.5			3	
2	ХАМО ДХ Баянхонгор, Баян-Овоо	3.5				3
3	Байдрагийн хөгжил Баянхонгор, Жаргалант	2.5	3		3	
4	Газар шороо ард түмний баялаг Говь-Алтай, Есөнбулаг	3			2.5	
5	Ван тайж Говь-Алтай, Есөнбулаг	0.5			2	
6	Хутагтын үр сад Дорноговь, Айраг				1	
7	Энхмөнх эргэх холбоо Төв, Заамар			1.5	1.5	
8	Тосон ундрага Заамар Төв, Заамар		1			10
9	Үйлдвэрлэлийн бус аргаар ашигт малтмал олборлогчдын нэгдсэн холбоо Төв, Заамар	0.5				
10	Дууш мандал хайрхан холбоо Сэлэнгэ, Мандал				0.5	
11	Буянтын хөндий Шарын гол Дархан-Уул, Шарын гол				2.8	
Нийт		12.5	4	1.5	16.3	13

ДӨРӨВ. БИЕТ НӨӨЦ

Судалгаанд хамрагдсан 25 ТББ-ын ашиглаж байгаа тоног төхөөрөмжийн 10.4 хувь компрессор, 12.2 хувь паажуур (хуурай баяжуулах төхөөрөмж), 8.3 хувь метал хайгч, 14.7 хувь том мотор, 16.8 хувь жижиг мотор, 18.1 хувь цохилтот өрөм /молоток/, 6.7 хувь усан буу/скруббер/, 7.7 хувь помп, 5.1 хувь нь хувийн тээрэмтэй байна.

Хүснэгт 9. Судалгаанд хамрагдсан бичил уурхайчдын ашиглаж буй тоног төхөөрөмжийн тоон мэдээлэл, төрлөөр

Тоног төхөөрөмжийн нэр	Шинэ тоног төхөөрөмжийн тоо	Хуучин тоног төхөөрөмжийн тоо	Нийт	Хувь
Компрессор	111	132	243	10.4
Паажуур	149	135	284	12.2
Метал хайгч	70	123	193	8.3
Том мотор	183	161	344	14.7
Жижиг мотор	209	183	392	16.8
Цохилтот өрөм (молоток)	196	226	422	18.1
Усан буу (скруббер)	74	80	154	6.7
Помп	85	95	180	7.7
Бусад (хувийн тээрэм)	67	51	118	5.1
Нийт	1144	1186	2330	100


Хувиараа ашигт малтмал олборлож байсан бичил уурхайчид зохион байгуулалттай бичил уурхайн хэлбэрт шилжиж баталгаатай ажлын байртай болсны бас нэг үр өгөөж нь бичил уурхайчид техник, тоног төхөөрөмж худалдан авах, шинэчлэхэд хөрөнгө оруулалт хийж, уурхайд ашиглаж буй шинэ тоног төхөөрөмжийн тоо нэмэгдсэн гэж нийт судалгаанд оролцогчдын 58.8 хувь нь үзжээ. Бичил уурхайчид тоног төхөөрөмжөө шинэчилж, сайжруулсан нь бичил уурхайчдын хөдөлмөрийг тодорхой хэмжээгээр хөнгөвчилж, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэхэд эерэг нөлөө үзүүлсэн байна. Ийнхүү бичил уурхайчдын үйл ажиллагаа албажсан нь бичил уурхайчдын биет болон санхүүгийн нөөц нэмэгдэхэд нөлөөлжээ.

ТАВ. НИЙГМИЙН НӨӨЦ

Бичил уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ТББ, нөхөрлөлийн зохион байгуулалт, чадавх бэхжүүлэхэд гарсан өөрчлөлт

2010 онд Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт орж, бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам батлагдаж бичил уурхайн хууль эрх зүйн орчин бүрдсэнээр хувиараа ашигт малтмал олборлох хэлбэрээс бүртгэгдээгүй нөхөрлөлийн зохион байгуулалтад шилжсэн нь бичил уурхайн салбарт гарсан томоохон өөрчлөлт болжээ. Энэхүү судалгаанд хамрагдсан 1827 бичил уурхайчныг эгнээндээ нэгтгэсэн 261 нөхөрлөл, 25 ТББ-ын үйл ажиллагаа бичил уурхайн байгууллагын бүтэц бий болж төлөвшиж байгааг харуулж байна.

Зураглал 2. Бичил уурхайчдын ТББ-ын бүтэц зохион байгуулалт



Судалгаанд Баянхонгор аймгийн Баян-Овоо, Галуут, Бөмбөгөр, Жаргалант, Говь-Алтай аймгийн Есөнбулаг, Дорноговь аймгийн Айраг, Дундговь аймгийн Хулд, Өлзийт, Төв аймгийн Замар, Сэлэнгэ аймгийн Мандал, Баянгол, Ерөө, Орхонтуул, Түнхэл, Дархан-Уул аймгийн Шарын гол суманд бичил уурхайн үйл ажиллагаа явуулж буй 25 ТББ-ын 261 нөхөрлөл хамрагдсан ба нөхөрлөлүүд хамгийн цөөн нь 10-13 гишүүнтэй, олон нь 30-40 гишүүнтэй байна. Бичил уурхайчдын бүртгэгдээгүй нөхөрлөл, ТББ-ын бүтэц зохион байгуулалт нь хөдөлмөрөө хорших, ажил үүргээ хуваарилах, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны

шаардлага хангах, ашиг орлогоо хуваах, дундын сан байгуулах, тоног төхөөрөмжийн ашиглалтыг сайжруулах, дотоод хяналт тавих, зөрчил маргааныг шийдвэрлэхэд одоогийн түвшинд зохистой бүтэц бүрдсэн гэж дүгнэж болох бөгөөд цаашид аж ахуйн нэгжийн хэлбэрт шилжих хэрэгцээ шаардлага байна.

- **Бичил уурхайн үйл ажиллагаа зохион байгуулалтад орсноор хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангагдаж уурхайн осол, гэмтлийн тоо буурч байна.**

Судалгаанд хамрагдсан бичил уурхайн ТББ, нөхөрлөлийн гишүүдийн 63.1 хувь нь хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны сургалтанд хамрагдаж, осол гэмтэл, эрсдлээс өөрийгөө болон бусдыг хамгаалах ур чадвартай болсон, 57.7 хувь нь ажлын байрны аюулгүй ажиллагааг мөрдөх зааварчилгааг өдөр бүр авдаг болсон, 54.2 хувь нь нөхөрлөлийн гишүүдэд шаардлага тавьдаг болжээ. (Зураг 3)



Судалгааны дүнгээр, 2012 оны байдлаар судалгаанд хамрагдсан 25 ТББ-аас Алтан усны хөгжил, Тахилгат лусын булаг, Буянтын хөндий Шарын гол ТББ-уудад нийт 5 осол аваар бүртгэгдсэн бол 2013 онд 4 ТББ-ын хэмжээнд 4 осол аваар бүртгэгдсэн нь зохион байгуулалтад орохоос өмнөх мөн үетэй харьцуулахад осол аваарын тоо буурах хандлагатай байгааг судалгаанд хамрагдсан бичил уурхайчид тэмдэглэж байсан. Осол аваарын тоо буурахад

аюулгүй ажиллагааны сургалт, нөлөөллийн үйл ажиллагааны чанар, хүртээмж сайжирсан, сайн дурын авран туслах багийн гишүүдийн бичил уурхайчдад үйлчилгээ үзүүлэх ур чадвар нэмэгдсэн зэрэг хүчин зүйлүүд нөлөөлжээ.

- **Бичил уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ТББ-ууд туршлага судлах, сургалт нөлөөллийн үйл ажиллагаанд хамрагдах, гишүүдийн хурал, уулзалт зохион байгуулах, төр засаг, сум орон нутгийн удирдлагуудад үгээ хэлэх зэргээр чадавхжиж, эрх мэдэлжсэн нь судалгааны баримтаар ажиглагдлаа.**

Сүүлийн нэг жилийн байдлаар судалгаанд хамрагдсан 25 ТББ-ын 261 нөхөрлөлийн гишүүдийн дунд давхардсан тоогоор хөдөлмөр хамгаалал, хууль эрх зүй, бизнес, санхүү, татвар, зөрчил маргаан шийвэрлэх арга зам, зохион байгуулалтын чиглэлээр олон төрлийн чадавх бэхжүүлэх сургалт 812, туршлага солилцох аялал, уулзалт, үзүүлэх сургууль 84, соёл урлагийн арга хэмжээ 143, төрөл бүрийн спортын уралдаан тэмцээн 107, орон нутаг, уул уурхайн компанитай 242 уулзалт тус тус зохион байгуулагдсан байна. 25 ТББ-ын 261 нөхөрлөлөөр харьцуулан чадавх бэхжүүлэх үйл ажиллагааг давхардсан тоогоор харуулахад дунджаар нэг ТББ байгууллагын гишүүд хурал 51 удаа, сургалт 3 удаа, орон нутаг, уул уурхайн компанитай хийх уулзалт 9 удаа, туршлага солилцох аялал, уулзалт 3 удаа, соёл урлагийн арга хэмжээ 5 удаа, ТББ, нөхөрлөлийн нэрэмжит тэмцээн уралдаан 4 удаа тус тус зохион байгуулжээ. Энэ нь бичил уурхайчдын байгууллага тогтвортой үйл ажиллагаа явуулж, гишүүддээ үйлчилгээ үзүүлж байгааг харуулж байна.

Жишээ

Буянтын хөндий Шарын гол ТТБ 60 орчим нөхөрлөлтэй, давхардсан тоогоор жилд хамгийн олон удаа буюу 191 удаа хуралдсан байна. Судалгааны мэдээлэл цуглуулах үеэр судалгаанд хамрагдсан зарим нөхөрлөлийн ахлагч нар шаардлагатай тохиолдолд 7 хоног бүр нөхөрлөлийн хурлаа хуралдуулдаг, 7 хоногт 2-3 удаа нөхөрлөлийн хурал уулзалт хийдэг гэж хариулжээ.


(“Бичил уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ТББ-уудын нийгэм эдийн засаг болон амьжиргаа” судалгаа, 2013)

- Судалгаанд хамрагдсан 25 ТББ-ын хувьд сум орон нутгийн удирдлага, уул уурхайн компанитай гурван талт гэрээгээр хамтран ажиллах эхлэл тавигдсан нь нийт судалгаанд хамрагдсан ТББ-ын 20 хувь нь 2 талт гэрээгээр, 24 хувь нь 3 талт гэрээгээр, 44 хувь нь аман тохиролцоогоор ажилладаг гэж хариулснаас үзэж болно. Харин нийт судалгаанд хамрагдсан бичил уурхайчдын 12 хувь нь гэрээ байгуулаагүй гэсэн хариулт өгчээ.



Бичил уурхайн үйл ажиллагаа явуулж буй ТББ, нөхөрлөлийн гишүүд үйл ажиллагаагаа албажуулж зохион байгуулалтад орсноор бичил уурхайн ТББ-уудын 62.5 хувь нь бичил уурхайн зориулалтаар газар ашиглах эрхтэй болсон, 58.9 хувь нь хамтын зохион байгуулалтаар ажиллах болсон, 52.3 хувь нь дэвшилтэт тоног төхөөрөмж хэрэглэх сонирхолтой болсон, 46.8 хувь нь бичил уурхайн үйл ажиллагааг хуульчилснаар олборлодог бүтээгдэхүүний хэмжээ нэмэгдсэн, 45.8 хувь нь Үндсэн хуулиар баталгаажсан оролцох эрхээ хэрэгжүүлж эхэлсэн (үг хэлэх, санал бодлоо илэрхийлэх, хуралд оролцох г.м), 31.3 хувь нь нутгийн иргэд, малчид, орон нутгийн засаг захиргаа, уул уурхайн компани бичил уурхайчдыг хүлээн зөвшөөрснөөр хөөгдөж туугдахгүйгээр хуулийн хүрээнд баталгаатай нөхцөлд ажиллах боломж бүрдсэн гэж хариулсан нь бусад хариултуудтай харьцуулахад хамгийн өндөр хувьтай илэрчээ.

(Зураг 5)



Жишээ

ИТХ-ын төлөөлөгч болон ИТХ-ын даргаар: “ХАМО ДХ”, Баянхонгор аймаг, Баян-Овоо сум, “Үйлдвэрлэлийн бус аргаар ашигт малтмал олборлогчдын нэгдсэн холбоо”, Төв аймаг, Заамар сум, “Хүлд хөгжлийн төлөө хамтдаа”, Дундговь аймаг, Хүлд сум


Иргэдийн нийтийн хурлын тэргүүлэгчээр: “Алтан усны хөгжил”, Баянхонгор аймаг, Баян-Овоо сум, “ХАМОДХ”, Баянхонгор аймаг, Баян-Овоо сум, “Байдрагийн хөгжил”, Баянхонгор аймаг, Жаргалант сум, “Дууш мандал хайрхан холбоо”, Сэлэнгэ аймаг, Мандал сум, “Хүлд хөгжлийн төлөө хамтдаа”, Дундговь аймаг, Хүлд сум, “Тосон Заамар ундрага” Төв аймаг, Заамар сум

Багийн засаг даргаар:” ХАМОДХ”, Баянхонгор аймаг, Баян-Овоо сум, “Байдрагийн хөгжил”, Баянхонгор аймаг, Жаргалант сум, “Алтан усны хөгжил”, Баянхонгор аймаг, Баян-Овоо сум

Сумын Засаг даргаар: “Өлзийтийн хишиг буян”, Дундговь аймаг, Өлзийт сум

(“Бичил уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ТББ-уудын нийгэм, эдийн засаг болон амьжиргаа” судалгаа, 2013)

Зураглал 3. Бичил уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ТББ болон бусад оролцогч талуудын хамтын ажиллагаанд гарсан зэрэг өөрчлөлт



ЗӨВЛӨМЖ

Судалгааны үр дүн, дүгнэлтэд тулгуурлан төрийн захиргааны төв болон орон нутгийн засаг захиргаа, өөрөө удирдах ёсны байгууллага, бичил уурхайчдын ТББ болон ТБУТ-д хандан дараах зөвлөмжүүдийг гаргаж байна.

Төрийн захиргааны төв байгууллагууд болон Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагуудад:

1. Монгол Улсын эдийн засагт бичил уурхайн салбарын үзүүлж буй хувь нэмрийг хүлээн зөвшөөрч Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт орж, мөн 2010 онд Засгийн газрын тогтоолоор “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ыг баталснаар бичил уурхайн үйл ажиллагааны эрх зүйн орчин бүрдсэн хэдий ч түүний хэрэгжилт хангалтгүй байгааг анхааралдаа авах,

2. Цаашид бичил уурхайчдын талаарх төрийн бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх, тодруулбал бичил уурхайн эрх зүйн орчныг боловсронгуй болгох, орон нутгийн тусгай хэрэгцээнд бичил уурхайн зориулалтаар газар олгох асуудлыг одоо мөрдөгдөж байгаа хуулийн хүрээнд шийдвэрлэхэд тулгарч байгаа хүндрэл бэрхшээлийг арилгах, орон нутгийн засаг захиргааны байгууллагууд орон нутгийн түвшинд газрын асуудлыг шийдвэрлэх эрх мэдэл олгох арга хэмжээ авах,

Тогтвортой бичил уурхай төсөлд:

1) Бичил уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй бичил уурхайчдын ТББ, нөхөрлөлийн гишүүдэд олон нийтийн оролцоонд тулгуурласан хандлагаар ажиллах, хүний эрхэд суурилсан хандлагын талаарх мэдлэг мэдээллийг хүргэх, түүнийг хэрэгжүүлэх чадавхийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх,

2) Бичил уурхайчдын ТББ-ын гишүүдийн үүрэг хариуцлагыг дээшлүүлэх, нийгмийн болон хамтын зан үйлийг төлөвшүүлэх, чадавх бэхжүүлэх сургалтыг хөдөлмөрийн аюулгүй байдал, нөхөн сэргээлтийн сургалтуудын нэгэн адил ач холбогдол өгч зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх,

Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоонд:

1) Судалгаанд хамрагдсан 1827 бичил уурхайчны 64 орчим хувь нь бичил уурхайгаас амьжиргааны эх үүсвэрээ бүрдүүлдэг бөгөөд нэг бичил уурхайчин сард дунджаар 350.000 орчим төгрөгний орлого олдог гэж хариулсан нь бичил уурхайн үйл ажиллагаа нь МУ-ын эдийн эдийн засагт дорвитой хувь нэмэр оруулах боломжтой салбар болохыг харуулж байна. Цаашид Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбооны гишүүн ТББ-уудын мэдээлэл, тоо баримт дээр түшиглэн бичил уурхайчдын тоо, олборлолт явуулж байгаа газрын байршил, бичил уурхайн салбарын Монгол Улсын эдийн засагт оруулж буй хувь нэмрийг тодорхойлох, бичил уурхайчдын орлого, татвар төлөлт, эрүүл мэнд, нийгмийн даатгалд хамрагдалтын талаарх тоон мэдээллийг бүртгэх, мэдээллийн сан байгуулах, мэдээллийн санг байнга шинэчилж, холбогдох байгууллагууд болон олон нийтэд мэдээлдэг байх,

2) Бичил уурхайчдын амьжиргааны одоогийн хүрсэн түвшинг дордуулахгүйн тулд, бичил уурхайчдыг жижиг дунд үйлдвэрийг дэмжих, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамруулах, бизнесийн зээл авахад нь дэмжлэг үзүүлэх, эдгээр арга хэмжээнд ялангуяа эмэгтэй бичил уурхайчдын оролцоог илүүтэй хангах, бичил уурхайгаас олсон орлогоо хуримтлуулж бизнесийн өөр салбарт хөрөнгө оруулалт хийх санал санаачлагыг хөхүүлэн дэмжих,

3) Бичил уурхайчдыг биологийн нөхөн сэргээлт хийх, мод суулгац тарих зэрэг ажилд татан оролцуулж байгаль орчинд ээлтэй ажлын байр бий болгох замаар бичил уурхайчдын амьжиргааг дэмжих, орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэхийн тулд орон нутгийн засаг захиргаа, байгаль орчны мэргэжлийн байгууллагуудтай хамтарч ажиллах,

4) Судалгаанд оролцогчдын 4 орчим хувь нь сургууль завсардсан, сургуулийн насны хүүхэдтэй, 5 орчим хувь сургуулийн насны ажил эрхэлдэг хүүхэдтэй гэж тус тус хариулсан байгааг үндэслэн цаашид Хүүхдийн эрхийн конвенц, Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай конвенцийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд сургуулийн насны, сургууль завсардсан хүүхдийг сургуульд

хамруулах, бичил уурхайн хүнд хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдийг энэхүү хүнд хөдөлмөрөөс хөндийрүүлэх, хөдөлмөр эрхлүүлэхгүй байх шаардлагыг ТББ, нөхөрлөлийн тэргүүн, ахлагч болон гишүүдэд тавих, энэ чиглэлээр орон нутгийн засаг захиргаатай хамтарч ажиллах

5) Бичил уурхайн эрх зүйн орчныг сайжруулах, бичил уурхайчдын олборлолт явуулах эрхийг баталгаажуулах, бичил уурхайчдыг дэмжсэн, эерэг шийдвэр гаргахад нөлөөлөх нөлөөллийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх,

Бичил уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ТББ-уудын гишүүдэд:

1) Хууль, тогтоомжийн хүрээнд байгаль орчны болон нийгмийн хариуцлагатай үйл ажиллагаа явуулах, төрийн болон төрийн бус байгууллагуудтай нягт хамтран ажиллах,

2) Орон нутгийн засаг захиргаа, МБУНДХ болон бичил уурхайчдын ТББ-аас явуулж буй үйл ажиллагаанд идэвх санаачлагатай оролцох,

3) Нэн тэргүүнд хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм, заавар, шаардлагуудыг мөрдөж ажиллаж, өдөр тутмын ажилдаа хэвшүүлэх,

4) Бичил уурхайчид ирээдүйдээ чиглэсэн хуримтлал бий болгоход анхаарч бичил уурхайгаас гадна орлогын эх үүсвэр бий болгох өөр бизнест хөрөнгө оруулалт хийх боломжийг эрэлхийлэх,

5) Эрүүл мэндийн даатгал, нийгмийн даатгалд хамрагдаж болзошгүй эрсдэлээс өөрсдийгөө хамгаалах, ирээдүйгээ баталгаажуулах,

Орон нутгийн өөрөө удирдах болон засаг захиргааны байгууллага, холбогдох мэргэжилтнүүдэд:

1) Зарим бичил уурхайчдын ТББ, нөхөрлөлүүд сумын Засаг даргатай болон тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн компаниудтай 2 болон 3 талт гэрээ байгуулан ажилладаг, цаашид энэхүү гэрээний хэрэгжилтэд аль аль талаасаа хяналтаа сайжруулж, гэрээний хэрэгжилтийн тайланг орон нутгийн иргэдэд нээлттэй мэдээлдэг байх,

2) Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох тухай журмын 2-3 дугаар зүйлд бичил уурхайн талаархи сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, сумын Засаг даргын эрх, үүргийг зохицуулсан байдаг. Журамд заасанчлан бичил уурхайчдын нөхөрлөлүүдэд эрх зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэх, сум, дүүргийн хэмжээнд бичил уурхайн зориулалтаар олгосон газрын кадастрын нэгдсэн бүртгэл, олборлолтын мэдээг хөтлөх, бичил уурхай эрхлэгчдэд эрүүл мэндийн болон нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх, хүүхдийг нь сургууль, цэцэрлэгт хамруулах арга хэмжээ авах, бичил уурхайчдыг татвар төлөх, даатгалд хамруулах, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрмийг мөрдүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, зохицуулалтаар хангах үүргээ биелүүлж ажиллах,

3) Сумын Засаг дарга уул уурхайн компаниудтай “Нийгмийн хариуцлагын гэрээ”-г байгуулж ажилладаг. Энэхүү гэрээнд зохион байгуулалтад орж ажиллаж байгаа бичил уурхайчдыг дэмжиж ажиллах заалтуудыг оруулах

Швейцарийн хөгжлийн агентлагийн Тогтвортой бичил уурхай төсөл
Нийгмийн бодлого хөгжлийн судалгааны хүрээлэн
2014 он

Судалгааны баг


Судалгааны багийн ахлагч: Ц.Одгэрэл (докторант)

Судалгааны зөвлөх Т.Бүрэнжаргал (доктор, проф)

Судалгааны багийн гишүүд:

Ц.Одгэрэл	МУИС-ийн Социологи, Нийгмийн ажлын тэнхимийн докторант
Т.Бүрэнжаргал	МУИС-ийн Социологи, Нийгмийн ажлын тэнхимийн багш, доктор, проф
Н.Болдмаа	МУИС-ийн Социологи, Нийгмийн ажлын тэнхимийн багш, доктор, проф
Б.Содбаяр	Улаанбаатар төмөр замын удирдах газрын статистик бүртгэл мэдээллийн технологийн төвийн программист
О.Энхболд	Улаанбаатар төмөр замын удирдах газрын статистик мэдээллийн төвийн программист
Б.Оюунбат	Улаанбаатар төмөр замын удирдах газрын статистик мэдээллийн төвийн оператор
В.Батгэрэл	Нийгмийн бодлого, хөгжлийн судалгааны хүрээлэнгийн судлаач

“Цагаан цахирт” дахь бичил уурхайчдын
суурьшлын бүсүүдийн байршил



БИЧИЛ УУРХАЙЧДЫН ТҮҮХЭЭС...

- “Нинжа” гэж нэр хоч зүүж хувиараа ашигт малтмал олборлож явсан хүмүүс өөрчлөгдөж хэрхэн өнөөдрийн хариуцлагатай бичил уурхайчин болсон, тэдний амьжиргаа хэрхэн өөрчлөгдөж байгаа талаарх судалгаанд оролцсон хүмүүсийн бодит амьдралын түүхээс...
- Тэд хэрхэн эвлэлдэн нэгдэж өөрсдийн эрх ашгийг хамгаалах бичил уурхайн ТББ-ыг байгуулж ажиллаж ирсэн туршлагаас...



Борнуурын Наранцогт

(Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо, Тэргүүн)

Алаг эрээн хорвоод хүмүүс өөрсдийн зам мөрөө гаргахдаа зөвхөн сайн талаас нь харж, тэмцэж, унаж, босож явдгийн хамгийн тод жишээ Бэлхүүгийн Наранцогт билээ. Тэрээр Төв аймгийн Борнуур сумандаа аавынхаа захиасыг биелүүлэн өвөг дээдсийнхээ нутгийг сахиж сайхан амьдарч байгаа нэгэн. Б.Наранцогтын сайхан амьдрал сайн аавтай нь салшгүй холбоотой. Тэрээр “Би эцгийнхээ генээр амьдарч байна. Их дээд сургууль төгсөж мэргэжил боловсрол эзэмшин, өөрийгөө хөгжүүлсэн бол үүнээс илүү амьдрах байлаа” хэмээн ярих дуртай.



Б.Наранцогт 2011 он

Түүний аав Шаравжамцын Бэлхүү нь Борнуур сумын Шар хоолой бригадын тоо бүртгэгчээс ажлын гараагаа эхэлж 1960 оноос сумын ерөнхий нягтлан бодогчоор ажиллаж байжээ. Аав нь нутгийн олондоо хүндлэгдсэн, хөдөлмөрч хичээнгүй, боловсролтой нэгэн байсан бөгөөд тухайн үеийн намын томилолтоор ажлаараа доголдож байсан сангийн аж ахуйнуудыг хөл дээр нь босгоход хувь нэмрээ оруулсан тэргүүний сэхээтнүүдийн нэг байжээ. Ш.Бэлхүү гэдэг хүний амьдралын ухаан, манлайлах ур чадвар хүүд нь өвлөгдөн үлдсэний тод жишээг хүү Наранцогтынх нь бичил уурхайн салбарт оруулж байгаа хувь нэмэр, амжилтуудаас харж болно.

Бэлхүүгийн Наранцогтыг амьдралын ухаантай, хөдөлмөрч, бүтээлч хүн гэдгийг Борнуурынхан мэднэ. Одоогоор сумын ИТХ-ын төлөөлөгч тэргүүлэгч, Сурын холбооны тэргүүн, ХАМО компаний захирал Цогтоо гэх тодотголудыг нь сонсоход л түүнийг ямар их хөдөлмөрч хүн бэ гэдгийг ойлгоно. Мөн өөрийн амьдралаас гадна сум орон нутгийнхаа хөгжил, олон хүний амьжиргаанд хувь нэмрээ оруулж буйг харуулж байгаа хэрэг юм.



Олон улсын зөвлөхүүдийн хамт 2009 он

Анх 1998 онд Борнуур сумын Сүжигт ууланд байрлах алтны орд газарт Зүүнхараагаас зургаан хүн, Борнуураас ганц нэг хүн алт олборлож байгаа тухай сураг сонсжээ. Ганц нэг хүн байна гэдэг сургаар Сүжигт уул руу явж нөхцөл байдлыг газар дээр нь үзэж юу хийж болохыг гярхайгаар харж алтыг нь худалдан авч оронд захисан зүйлсийг нь хүргэж өгдөг байлаа. Сумын төвд эл хуль, оршин суугчид ажлын байргүйн улмаас өөр газар руу амьжиргаа хөөж явцгаасан үе байсан. Сүжигт ууланд алт гарсан сургаар нутгийн хүмүүс эргэн ирж сум орон нутаг хөл хөдөлгөөнд орж билээ.

Олон хүмүүс олборлосон алтаа уур нүдүүрээр нүдэж, мөнгөн усаар бариулаад өөрсдөө ч хордоод, бусдыг болон байгалиа ч хордуулаад байгаа нөхцөл байдлыг хараад тухайн үед Б.Наранцогт Борнуур сумын Засаг дарга Ц.Гүнбаатартай тохиролцон мөнгөн усны хэрэглээг сумаас холдуулж төвлөрсөн тээрийг ажиллуулах санаачилга гаргажээ.

Улмаар хүдэр боловсруулах тээрэм, алт худалдан авах цэг ажиллуулж одоогийнхоор бол нэг цэгийн үйлчилгээг анх санаачлан хэрэгжүүлж эхэлсэн байна. 1999-2003 ондуудад Борнуур суманд мөнгөн усны хэрэглээ газар авч алт олборлодог айл болгон ашиглаж байлаа. Энэ нь хүмүүсийг мөнгөн усны хордлогоос холдуулж эхэлсэн анхны алхам байлаа. 2007 онд Монгол Улсын Засгийн газраас мөнгөн усыг ашигладаг төвлөрсөн тээрийг хаах тогтоол гарч татан буулгаснаар мөнгөн усны хэрэглээ нууц байдалд шилжжээ.



Туришлтын цехийн нээлт 2009 оны 2-р сарын 10

Борнуур сумын хувиараа ашигт малтмал олборлогч 32 хүн хамтран санаачилж 2007 оны 11-р сарын 29-нд “Бичил уурхайчдын холбоо” ТББ-ыг байгуулан удирдах зөвлөлд Б.Ууганбаяр, Р.Цогбадрах, Д.Цэнгэл, А.Отгонхишиг Б.Наранцогт нар сонгогдон ажиллаж байжээ. Удирдах зөвлөлийн таван гишүүн хурлын шийдвэрээрээ мөнгөн ус хэрэглэхгүй алтыг ялгах ямар арга байгааг судлахаар 2007 оны 12-р сард Тогтвортой бичил уурхай төслийнхөнтэй анх уулзсан түүхтэй. Тухайн үед Тогтвортой бичил уурхай төслийн зохицуулагч байсан Б.Хулдорж тэдний саналыг маш сайхан хүлээж авснаар хамтын ажиллагаа эхэлсэн байна. “Хүрз шороо нийлүүлдэг хүмүүс одоо үзэг цаас нийлүүлж санаагаа цаасан дээр буулгаад ир” гэсэн нь 20 жил костюм өмсөж, үзэг цаас нийлүүлж үзээгүй хүнд хэцүү” байлаа хэмээн Наранцогт дурсав. Үүний дараа Тогтвортой бичил

уурхай төслийнхний туслалцаатайгаар мэргэжлийн хүмүүсийн дэмжлэг авч Монголын хоршооллын сургалт мэдээллийн төвийн багш А.Мөнхжаргал, Р.Ганбат нартай таван өдөр ажиллаж, санаагаа төсөл болгон буулгасан. Ийнхүү анх “ХАМО” компаний төсөл цаасан дээр буусан билээ. Олон нийтийн эрх ашгийг хамгаалж байгаа учраас хувьцаа босгоод компани байгуулъя гэтэл хувьцаат компани байгуулна гэдэг амаргүй байсан. Гишүүдээ цуглуулж, хөрөнгө оруулагчдыг олохоор Борнуур сумын том газруудтай уулзаад нэг ч төгрөгний хөрөнгө босгож чадсангүй. Тэгээд одоо яах вэ гэдэг асуудал тулгарч, нэг нэгнийгээ ойлгож байгаагаараа тавуулаа 2008 оны 3-р сарын 3-нд компаниа байгуулсан юм. Үүнээс хойш Тогтвортой бичил уурхай төсөлтэй холбоотой ажиллаж байна.



*“ХАМО” ХХКомпаний гадна талбай, ШХА, ТБУТ,
Швейцарийн Гадаад хэргийн яамны төлөөлөгчдийн хамт мод
тарив. 2010 он*

Нэг хэсэг мөнгөн усны хэрэглээ хэрээс хэтэрлээ гэж шуугисан. Мэргэжлийн байгууллагууд шалгалт бүрт тоо баримттай нь дэлгэж байсан тэр үед мөнгөн усгүй технологийн талаар төр засгийн хэмжээнд ярьж эхэлсэн. Засгийн газар, орон нутгийн төр захиргааны байгууллагын дэмжлэгээр 450 орчим сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар туршилтын цехийг цогцолбор маягаар байгуулжээ. Мөнгөн усгүй технологитой усан тээрэм 2009 оны хоёрдугаар сард ашиглалтад орж үйл ажиллагаа явуулсан. Цехээ

байгуулахад гаргасан зардлуудыг төлөхийн зэрэгцээ сан байгуулаад бичил уурхайг дэмжих, бичил уурхайчдын сайн сайхны төлөө зарцуулж байна. Сум орон нутгийн хөгжилд ч бас зориулж байна.

Мөнгөн ус огт хэрэглэдэггүй технологийг гравитацийн арга буюу хүндийн хүчний үйлчлэлээр алт баяжуулах технологи гэж нэрлэдэг. Технологийн энэ шийдлийг “ХАМО” компани Тогтвортой бичил уурхай төслийн техникийн багтай хамтран олон янзын төхөөрөмжийг туршиж байж гаргажээ. Тогтвортой бичил уурхай төсөл бичил уурхайн техникийн эксперт болон бусад мэргэжилтэн, зөвлөхүүдийг гадаадаас урьж ажиллуулснаас гадна ШУТИС-ийн ашигт малтмалын баяжуулалтын анги төгссөн дөрвөн инженер ажилласан. Энэ технологийн шугамны анхан шатны баяжуулалтын хэсэг нь хүдэр бутлагч “хацарт бутлуур”, дугуйт тээрэм, ахдагч болон хяналтын шлюзнээс бүрддэг. Харин гүйцээн баяжуулалтыг нь Англи улсад үйлдвэрлэсэн сэгсрэгч ширээн дээр хийдэг. Энэ утгаараа манай улсын энэхүү технологийг бусад улсууд сонирхож байна. Одоогоор улсын хэмжээнд мөнгөн усгүйгээр хүдэр боловсруулах 4 цех байгуулагдсны хамгийн анхных нь Борнуурын цех юм.



ХАМО ХХКомпаний захирал Б.Наранцогт. 2013 он

Амьдралын эрхэнд өөрөө өөртөө ажлын байр гаргаад төрийн оролцоо, дэмжлэггүйгээр гэр бүлээ тэжээгээд зогсохгүй орон нутгийнхаа эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ оруулаад амьдарч байгаа тэр олон хүнийг дэмжих хэрэгтэй.

Монгол улсын хэмжээнд бичил уурхай эрхлэгчид ТББ, нөхөрлөлийн зохион байгуулалтад орж ажиллахад Тогтвортой бичил уурхай төслийн үр нөлөө маш их байсан, одоо ч ач холбогдолтой хэвээр байна. Тогтвортой бичил уурхай төсөл бол “нинжа” нарыг бичил уурхайчин болгоход маш их хөрөнгө мөнгө зарцуулсан. Үүний хүчинд улс даяар бичил уурхайчид мэдээлэлтэй, мэдлэгтэй, тодорхой хэмжээнд боловсролтой бүхэл бүтэн системтэй үйл ажиллагаа явуулах боломжтой болж байна. Монголын төр бичил уурхайчдын төлөө хуруугаа ч хөдөлгөхгүй байсан үе саяхан. Гэтэл Тогтвортой бичил уурхай төсөл байгаа нь аз завшаан гэж боддог. ХАМО компаний хувьд хүсэл мөрөөдөл л байсан, хар ухаанаар л төсөөлж байсан, харин Тогтвортой бичил уурхай төслийн зүгээс бидэнд олон улсын туршлага, технологийн арга зүй зэрэг олон зүйлийг танин мэдүүлж сургаж өгсөн ачтан даа” хэмээн Наранцогт сэтгэгдлээ хуваалцан хуучилсан билээ.



*Бичил уурхайчдын анхдугаар их хурал 2013 он 5-р сарын 2
Төрийн ордон, анхны удирдах зөвлөлийн гишүүдийн хамт*

Орхонтуулын анхны бичил уурхайчин эмэгтэй

(Сэлэнгэ аймаг, Орхонтуул сум,

Орхонтуулын хишиг ТББ-ын тэргүүн)



*П. Даваасүрэн
2011 он*

Орхон, Туул голуудын үзэсгэлэнт бэлчир нутагт орших Орхонтуул суманд Пүрэвийн Даваасүрэн гэж ажилч хичээнгүй, зорьсондоо хүрэх эрмэлзлэл дүүрэн бүсгүй бичил уурхайн “Орхонтуулын хишиг” ТББ-ыг тэргүүлдэг. П.Даваасүрэн хуучнаар ЗХУ-ын Рязань хотод Хөнгөн хүнсний ТМС-д суралцаж 1986 онд төгсөж ирээд Сэлэнгэ аймгийн Сүхбаатар хотноо Гурил тэжээлийн үйлдвэрт, 1987 онд төрсөн нутагтаа “Дээж” үр тарианы компанид тус тус ажиллаж байлаа. Зах зээлийн нийгэмд шилжиж байсан тэр үед компаний үйл ажиллагаа зогсонги байдалд орж тэрээр 2000 онд ажилгүй болжээ.

П.Даваасүрэн нь гурван эрэгтэй дүүгээ дагуулаад аав ээжээсээ зөрөн байж Орхонтуулаасаа анх удаа Төв аймгийн Заамар сум руу алтанд явж эхэлсэн. Эцэг эх нь нуранги шороонд даруулахаас болгоомжлох, амь нас, эрүүл мэндээ байнга бодож байхыг захиж, айдас хүйдэстэй үлдсэн билээ.

Үүнээс хойш тэрээр хаана л алт гарсан гэж сонсогдоно тэнд очиж нинжа хэлбэрээр 10 орчим жил алт олборлон амьжиргаагаа залгуулж, үр хүүхдээ тэжээж, дүү нарынхаа сургалтын төлбөрийг төлөх зэргээр аав ээж, ах дүү нартаа хоол хүнсний мөнгө илүүлэн дэмжиж тусалдаг байлаа.

П.Даваасүрэн олон жил алт олборлож энд тэнд явахдаа хал үзэж халуун чулуу долоон байж амьжиргаагаа өдий зэрэгт хүргэсэн дайчин, шантрашгүй, зоримог эмэгтэй. Хүний нутагт хөөгдөж туугдан олон жилээр алт олборлож, амьжиргаагаа залгуулна гэдэг эмэгтэй хүнд битгий хэл эрэгтэй хүнд ахадсан ажил. Энэ олон жил бичил уурхайгаар ажиллахдаа аливааг ухаан зарж зохицуулах, шийдвэр гаргах, хүнтэй хэл амаа ололцох, баг хамт олноо удирдах чадварууд энэ эмэгтэйд заяасныг түүний амьдрал, ажил нотолж байна.

2011 онд “Орхонтуулын хишиг” ТББ-ыг байгуулах санаачлагыг гаргаж П.Даваасүрэн тэргүүнээр, удирдах зөвлөлд П.Ганпүрэв, Ё.Батхуяг, Ж.Отгонпүрэв, О.Бямбаа, Ч.Эрдэнэбат, Ж.Тунгалаг, Д.Намжилмаа нар сонгогдон 12 нөхөрлөл, 120 гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Орхонтуул суманд урьдын нинжа биш, харин тэд хариуцлагатай бичил уурхайн зохион байгуулалтад орж ажиллаж байгаа нь Даваасүрэнгийн хичээл зүтгэл юм.



*“Бичил уурхайчдын туршлага солилцох уулзалт” Дуган хад
жуулчны бааз 2014 он*

П.Даваасүрэн гишүүдээ эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд хамруулж, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, байгууллагын менежмент, хүний эрх, бизнес, санхүү, нөхөн сэргээлт зэрэг олон сургалтанд хамрагдсанаас гадна туршлага солилцох чуулга уулзалтанд тогтмол оролцож өөрийн мэдлэг чадвар, мэдээллээ байнга дээшлүүлж байдаг хөдөлмөрч бүсгүй. Бичил уурхайн ТББ-ын зохион байгуулалтаар ажилласнаас хойш Орхонтуул сумын удирдлагууд байнга дэмжиж тусалж байгаа хэдий ч орон нутагт үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн компанитай сайн хамтарч ажиллаж чадахгүй байна. ТББ-ын гишүүд Орхонтуул сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг уул уурхайн “Хурай” ХХК-ийн зөвшөөрөлтэй газарт олборлолт хийх хүсэлт гаргаж, гуравласан гэрээгээр ажиллахыг санал болгосон байна. Уг хүсэлтээ

анх байгуулагдсан цагаасаа хойш тавьсан ч “Хурай” ХХК-ийн зүгээс нааштай хариулт өгөөгүй байна.

Тиймээс бичил уурхайчид болон зарим орон нутгийн иргэд хамтран жагсаал цуглааныг сумандаа зохион байгуулсан. 120 бичил уурхайчны ард 300 гаруй хүний амьжиргаа байдаг. Харин энэ компани нь манай суманд 10 гаруй жил үйл ажиллагаа явуулж байгаа. Иймд орон нутгийн иргэдтэй хамтарч ажиллах цаг болсон гэж бодож байна. Удахгүй бидэнд нааштай хариу өгнө гэдэгт итгэж байна” хэмээн Даваасүрэн ярьж сууна.



Хурай компанитай хамтран ажиллах хүсэлтэй хариуцлагатай бичил уурхайчдын жагсаал “Орхон туулын хишиг” ТББ 2014 он

Бичил уурхай эрхэлж амьжиргаагаа дээшлүүлж, байнгын ажлын байр, тогтвортой орлого бий болгодог гэдгийг Даваасүрэн сайн мэднэ.

Анх өөрийн амьдарч байсан төмөр замын байраа хүлээлгэж өгөөд нинжа хэлбэрээр алт олборлож эхлэхэд гэр оронгүй болж байсан үе ч түүнд бий. Гэхдээ олсон орлогоороо охин нь хүнс, барааны дэлгүүр ажиллуулж, хүү нь биллиардын үйлчилгээг бичил уурхайчиддаа үзүүлэн орлогын өөр эх үүсвэрийг бий болгох замаар хуримтлал үүсгэн гэр оронтой болж өөдлөн дэвжсээр байна.

Даваасүрэн гурван хүүхэдтэй, үр хүүхдүүдээ сургуульд сургаж мэргэжил боловсролтой болгож байна. Хүү нь гагнуурчнаар ажиллаж байгаад Барилгын коллеж дүүргэсэн. Том охин нь Дархан-Уул аймагт дээд сургуульд англи хэлний орчуулагчаар төгсөж улмаар Улс төр менежментийн академийг дүүргэж ажил хөдөлмөр эрхлэн сайхан амьдарч байна. Бага охин нь ерөнхий боловсролын дунд сургуульд суралцдаг.



Бичил уурхайчдын хамт 2011 он

Түүний амьдралд хамгийн том түшиг тулгуур болдог хүн бол хань Б.Ганхүү юм.

Бичил уурхайчдынхаа эрх ашгийг хамгаалан олон хүнийг тогтвортой ажлын байртай болгохын төлөө зүтгэж тэмцэж яваа Даваасүрэн, түүний гэр бүл, үр хүүхдэд ажлын амжилт, аз жаргал, эрүүл энхийг хүсье.

Хулдын анхны бичил уурхайн 13-ын нэг

(Дундговь аймаг, Хулд сум)



Ш. Цэцэгээ 2014 он

Эх хүний сайхан сэтгэлээр аливаад хандах хандлагаа эрхэм болгож, тэр хэрээрээ ажил үйлс нь өөдрөг бүтэмжтэй яваа бичил уурхайчин эмэгтэй бол Шаравын Цэцэгээ юм. Тэрээр Дундговь аймгийн Хулд суманд бичил уурхайн үйл ажиллагаа явуулдаг “Тахилгат лусын булаг” ТББ-ын гишүүн “Баянхайрхан” нөхөрлөлийн ахлагчаар бусдыгаа манлайлан ажиллаж байна. 2005 онд найз Энхтуяа нь Дорноговь аймгийн Иххэт суманд хүрээд ир хэмээн “энд жоншин дээр ажиллавал мөнгө олох боломжтой байна” гэж

дуудаж анх уруу татсан гэдэг. Тэрээр 4-5 сар ажиллаад Хулд сум руугаа буцахдаа жонш хэмээх байгалийн баялгийг мөнгө болгож амьжиргаагаа дээшлүүлэх боломжтойг ойлгон сэтгэлийн мухартаа тээсээр иржээ. Тэр үед Хулдынхан амьдрахын эрхээр нутгаасаа явж, ажлын мөр хөөцгөөж, нэг хэсэг нь Иххэтийн жоншны уурхай руу очиж ажиллан гэр бүлээ тэжээж байлаа. Тухайн үед нинжа хэлбэрээр жонш олборлох нь орон нутгийн хүмүүсийн хувьд орлого олж амьжиргаа залгуулах ганц боломж байсан. Бүгд энэ хөдөлмөрийн хүнд хэцүүг мэддэг, хөөгдөж туугддаг ч суманд ажлын байр байхгүй, малчид малгүй болсон, орлого олох эх үүсвэр хомс зэргээс шалтгаалан ажилласаар л байлаа.

2007 оны 7-р сарын 1-нд Ш.Цэцэгээ хоёр хүүхдээ дагуулаад Дорноговь аймгийн Иххэт сумын Хамар усны уурхайд буцаж очин 3 жил ажилласнаар амьжиргаагаа ч овоо дээшлүүлж цэнхэр УАЗ-469 машин худалдаж авсан нь бусдын адил амьдралаа өөд татах итгэлийг өөртөө төдийгүй хүүхдүүддээ ч төрүүлж чадсан гэдэг. Тухайн үед Ш.Цэцэгээ Хулд суманд жижигхэн хүнсний мухлаг ажиллуулж

байсан ч түүнийгээ охиндоо орхиод Иххэт сумын жоншноос олсон мөнгөө дэлгүүрийн бараа болгон эргэлдүүлж түүгээрээ гэр бүлээ авч явдаг байлаа.

Тэрээр 9 хүүхэдтэй, хоёр хүү, долоон охинтой өнөр гэр бүлийг авч явах үүрэг хүлээсэн өрх толгойлсон эмэгтэй юм. Түүний нөхөр 1996 онд хорвоогийн мөнх бусыг үзүүлж үр хүүхдүүдээ өсгөж өндийлгөх их ачаа нуруун дээр нь бууснаар бичил уурхай руу орсон олон эмэгтэйчүүдийн нэг. Одоо хүүхдүүдийнх нь хамгийн бага нь 26 настай, 20 гаруй ач зээ нартай. Түүний хүүхдүүдээс хоёр охин, нэг хүү нь жонш олборлож байна.

Ш.Цэцэгээ хоёр хүүхэдтэйгээ 2010 онд Иххэт сумын Хамар усны уурхайгаас Хулд сумандаа иртэл нутгийнхан нь жонш гарч байна гээд л шуугицгааж байв. Тэр үед “Жонш гэж ямар чулуу вэ?, Мэдэх хүн байна уу?” гэж бие биенээсээ асууж сураглах нь Цэцэгээгийн хувьд нутгийнхандаа нөлөөлж бичил уурхайг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулах эхлэл байлаа.

Ш.Цэцэгээ олборлосон жоншоо борлуулах зорилгоор нэг удаа Хэнтий аймгийн Бор-Өндөрт явж байгаад замдаа Иххэт сумынхнаас хувиараа ашигт малтмал олборлож буй хүмүүс хэрхэн нөхөрлөл байгуулж хамтарч ажиллах тухай хоёр ширхэг гарын авлага олж авчээ. Тухайн үед Хулд сумын ИТХ-ын даргаар ажиллаж байсан Б.Энхжаргалд нэгийг өгч, нөгөөг нь өөрөө судлаж эхэлсэн байдаг. Энхжаргал дарга “Уул уурхай, жоншны тухай мэдлэггүй, нөхөрлөл хэрхэн байгуулах талаар ямарч ойлголтгүй байхад Ш.Цэцэгээ маань ном авчирч биднийг гэгээрүүллээ шүү” гэж ихэд баярлаж байсан гэдэг. Тэрхүү гарын авлагаа судалж “Хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам” (Засгийн газрын 72-р тогтоол)-ын дагуу иргэдийн санаачлагаар анх 13 нөхөрлөлийг байгуулж байсан. 2010 онд Засгийн газраас 308-р тогтоол батлагдсанаар 13 нөхөрлөлөө дахин байгуулж түүнээс хойш нөхөрлөлийн тоо нэмэгдсээр байна.

Анхны 13 нөхөрлөлийн ахлагч нар бичил уурхайчдыг зохион байгуулах, албажуулах ажилд хүчин зүтгэж өдий зэрэгт хүргэсэн болохоор өөрсдийгөө “Анхны 13” гэж ярих дуртай хэмээн Ш.Цэцэгээ дурсаж байна.



*Олборлолтын газар дээр
2014 он*

Хулд суманд уурхай ажиллахгүй бол орлогогүй болж, үйлчилгээнүүд хумигдаж айл өрхөд хоногийн хоолноос эхлээд л асуудал үүсч эхэлдэг. Хулдынхны амьдралын баталгаа бол энэ жоншны уурхай, тиймээс зөв зохистой ашиглах нь чухал.

Тэрээр Швейцарийн хөгжлийн агентлагийн Тогтвортой бичил уурхай төслийн зохион байгуулсан бичил уурхайн хууль эрх зүйн орчин, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, байгууллагын дотоод зохион байгуулалт, чадавхийг бэхжүүлэх зэрэг олон сургалт, зөвлөгөөнд

оролцож, мэдсэн сурсан зүйлээ бусадтайгаа байнга хуваалцаж байдаг идэвхтэй нэгэн билээ.

Ш.Цэцэгээ бичил уурхай эрхэлснээр бүх хүүхдээ өрх тусгаарлаж, машин унаатай, тогтвортой орлоготой, хүний дайтай амьдрахад нь өмөг түшиг болж явна. Гар хөдөлбөл ам тосдоно гэдэг Монгол ардын зүйр үг Цэцэгээ болон түүний үр хүүхдүүдийн амьдралтай нийцэж байна.

Нутгийн олондоо үлгэр дууриал болсон, үр хүүхдүүдээ гарыг нь ганзаганд, хөлийг нь дөрөөнд хүргэж өгсөн ажилч хичээнгүй, алдарт эх Цэцэгээдээ аз жаргал, эрүүл энхийг хүсье.

Шарын голын Оюунтоого

(Дархан-Уул аймаг, Шарын гол сум, “Буянтын хөндийн Шарын гол” ТББ-ын удирдах зөвлөлийн гишүүн)

Хийж байгаа аливаа ажлаа үр дүнтэй болгохыг байнга эрмэлздэг, хөдөлмөрч нэгэн бүсгүйн “нинжа”-гаас бичил уурхайчин болсон намтрыг сонсоход сонирхолтой байлаа. Энэ бүсгүй бол Шарын голын унаган охин Ц.Оюунтоого юм.

Дарханы Анагаах ухааны дунд сургуулийг эх баригч бага эмч мэргэжлээр төгсөөд Шарын гол сумандаа очсон боловч мэргэжлээрээ ажиллаж чадсангүй, Шарын голын нүүрсний уурхайд 1989-1993 онд ашиглалтын диспетчерээр ажиллаж байв.



III. Оюунтоого 2011 он

Монгол улс эдийн засаг, улс төр, оюун санааны томоохон өөрчлөлтийг нийгмийн шаардлагаар хийж байсан тэртээх 1993 онд машины сэлбэгийн наймаа эрхлэхээр ажлаасаа гарч зах зээлд өрсөлдөж өөртөө болон ирээдүйдээ хөрөнгө оруулах том зориг гаргаж 2003 оноос нөхөртэйгээ хамтран зүтгэсэн. Цаг хугацаа ээлжлэн олон жилийг ардаа өнгөрөөсөн ч сэлбэг оруулж ирдэг компаниуд бий болж санхүүгийн хувьд өр зээл тавихгүй өөрийн хөрөнгөөр л босох ёстой гэсэн ахархан бодолдоо гүйцэгдэж сэлбэгийн бизнес хэмээх зах зээлээс шахагдаад аргагүйн эрхэнд нутгаа бараадаж жижиг аж

ахуй хөтлөх сэм бодол өвөрлөж очсон билээ. 2009 онд нутагтаа буцаж ирсэн тэр үед нинжа гэж нэрлэгдэх хувиараа алт олборлох хүмүүсийн талаар дуулдаж байсан бөгөөд амьдрахын эрхээр нэг л мэдэхэд нөхөр Б.Наранбаярын хамт тэдний эгнээнд орсон байлаа. Тэр цагаас хойш одоогийн энэ ажил амьдралын түвшинд очтолоо сайн муу олон бартаат замыг туулжээ. Нөхөр Б.Наранбаяр нь бусдын адил нүх рүү орж, Оюунтогоо нүхний аман дээр жил гаруй зогсож ажиллахдаа өдөр бүр “хэзээ шороо нураад дарчих бол” гэсэн сэтгэлийн түгшүүртэй хувь тавилантайгаа эвлэрч чадахгүй байлаа. Хувиараа алт олборлож байгаа хүмүүсийн хүнд хүчир ажлыг хөнгөвчлөх, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааг хангах зорилго тавьж жижиг скруббер (алт угаадаг тоног төхөөрөмж) ажиллуулж эхэлсэн. 2013 оны 8 сараас түүнийгээ усан буу болгон сайжруулж мөнгөө хуримтлуулсаар байгаад эхний цаснаар баяжуулах цэг барьж 2013 оны 11 сараас 2014 оны 3 сарын 8 хүртэл усан буугаа ажиллуулж байлаа.



*ШХА-ийн ажилтнуудын хамт,
Буянт олборлолтын газар 2014 он*

Зөвхөн Шарын гол суманд ч биш өөр олон аймаг суманд ажлын байр дутмаг, олон малчид малаа зуднаар алдаж, амьдрахын эрхээр “нинжа” болж байсан тэр үед Швейцарийн хөгжлийн агентлагийн Тогтвортой бичил уурхай төсөл хэрэгжиж эхлээгүй бол өнөөдрийн бичил уурхайчдын хөгжлийг төсөөлж чадахгүй байлаа

гэж Ц.Оюунтогоо ярьж байна. Олон мянган нинжа нарын амьдралд том эргэлтийг хийсэн Тогтвортой бичил уурхай төслийн хамт олонд талархаж явдгаа илэрхийлж байсан. “Зарим нэг хүний хувьд Тогтвортой бичил уурхай төслийнхөн гэхээр хол сонсогдож байж болох ч миний хувьд аав ээжийгээ харж байгаа юм шиг баярладаг гэж хэлэх түүний чин сэтгэлийн үг нэгийг бодогдуулж байна. Талын нэг тарчихсан байсан нинжа нарыг зохион байгуулалтад оруулж албажуулан “Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо” гэж үндэсний хэмжээний байгууллагад нэгдсэн нь үнэхээр том амжилт билээ гэж бахархалтайгаар ярьж суугаа түүнээс ихийг мэдэж авлаа.



Буянт олборлолтын газар 2014 он

Ц.Оюунтогоо нь манлайлагч эмэгтэйчүүдийн нэг бөгөөд ТББ-ын бусад гишүүдээ хариуцлагатай бичил уурхайчин болох, хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулахад нь нөлөөлсөөр байна. Тэрээр бичил уурхайтай холбогдож амьжиргаагаа хэрхэн дээшлүүлснээ бахархалтайгаар ийнхүү дурсаж байна. “Би Шарын голд бараг л нүцгэн шахуу, аж ахуй хөтлөх том мөрөөдөлтэй хүн ээж дээрээ ирж байсан. Яг юунаас эхлэхээ мэдэхгүй Шарын голынхныгоо дагаад л мөнгөтэй болохын тулд дүүгийнхээ бэлэглэсэн хуучин машинаар алтанд явсан. Өмнө нь банкнаас зээл авах ямар их хүндрэлтэйг өөрийн биеэр мэдэрч байсан бол одоо хоёр ч банкны алтан карттай болсон нь бичил уурхайн л буян шүү дээ.” Мөн бичил уурхайн өгөөжөөр өрх тусгаарлаж, өнгөрсөн өвлөөс баяжуулах жижиг цэг

ажиллуулан одоо “Ланд” машин унаж байна хэмээн сайрхсан нь онгирч сагсуурсных бус өөрөөрөө бахархсаны цагаан аархал юм. Нэг их хурааж хуримтлуулсан мөнгө байхгүй ч гэсэн болгоод л явдаг, тийм болохоор бичил уурхайг албан ёсны салбар болоосой гэж хүсдэг хэмээх мөрөөдөл нь ганцхан түүнийх биш.



Бүх гишүүдийн хурал 2014 он



“Бичил уурхайчдын турилага солилцох уулзалт” 2014 он

Тэрээр эх хүн болохоор олон зүйлд санаа зовж эдгээр олон бичил уурхайчид, тэдний үр хүүхдүүдийнх нь ирээдүйг байнга гэгээлгээр хардаг. Гэхдээ хүйтэн нүхэнд өдөржингөө мөлхөж эрүүл мэндээ эрсдэлд оруулж байгаа бичил уурхайчдынхаа төлөө сэтгэлээ чилээж явдаг нь Оюунтогоогийн хүн чанартай нь холбоотой. Аюулгүй ажиллагааг мөрдөж ажиллахад нь бусдыгаа уриалан идэвх санаачлагатай ажиллаж байна.

Бичил уурхайгаар ажиллаж амьжиргаагаа залгуулах нь байнгын дардан замаар явдаггүй, хамгийн гол нь зохион байгуулалт хамтын ажиллагаа чухал гэдгийг онцлон хэлж байлаа.

Бичил уурхайчдынхаа сайн сайхны төлөө санаа тавьж сэтгэлээ чилээж, энэ салбарын хөгжилд өөрийн хувь нэмрээ оруулж яваа дайчин эмэгтэйдээ болон түүний гэр бүл, үр хүүхдүүдэд нь эрүүл энх, аз жаргалыг хүсье.

Бичил уурхайн манлайлагч бүсгүй

*(Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо,
Нарийн бичгийн дарга)*



Бичил уурхайчдын ХАБ-ын сургалтын үеэр 2013 он

Рэгзэнгийн Түмэндэмбэрэл гэдэг бүсгүйтэй ярилцаж суухад “санаа зөв бол заяа зөв” хэмээх зүйр үг сэтгэлд бууж байлаа. Хувь хүний аливаад хандах хандлага, мэдлэг туршлагаас гадна хичээл зүтгэл, эгэл жирийн бичил уурхайчдынхаа төлөө гэсэн түүний сэтгэл нь ажил амьдралын зөв гараанд хүргэсэн мэт санагдсан. Сүрлэг өндөр Алтай нутагт төрсөн аав, ээжийнхээ ажилч хичээнгүй чанарыг өвлөж авсан айлын отгон охин тэрээр бага насаа Төв аймгийн Борнуур суманд өнгөрүүлж 1990 онд Төв аймгийн Баянчандмань суманд Техник мэргэжлийн коллежид суралцсан байна. 1992 онд сургуулиа төгссөнөөс хойш ах нарынхаа гэрийн тавилга үйлдвэрлэдэг “Хорол” ХЭАА-д хээлэгч, Борнуур сумандаа фото зурагчнаар, үүний дараагаар жижиг хүнсний дэлгүүр ажиллуулж байжээ. 1990-ээд оны сүүлээр найздаа зээлүүлсэн барааныхаа мөнгийг авахаар нинжа нарын ажиллаж байсан Сүжигт ууланд очиж, өрөндөө авсан хагас шуудай чулуунаасаа 110.000 төгрөгтэй болсон нь тухайн үедээ хоёр машин өвсний үнэ болсон байна. Ийм тохиолдлоор Түмэндэмбэрэл бичил уурхайтай анх холбогджээ.

Эмэгтэй хүн, тэр тусмаа нялх үрсээ гэртээ орхин хувиараа алт олборлох нь хүнд хөдөлмөр гэдгийг өөрийн биеэр мэдэрсэн ч эхний жилүүдэд бусдын адил мөнгөн усны хор хөнөөлийг сайн мэддэггүй байжээ. Алт ялгах усан болон бөмбөлгөн тээрмийн үйлчилгээ бий болсноор айл өрхүүд гэр бүл, үр хүүхдүүдийнхээ дэргэд ууршуулж байсан мөнгөн усны хэрэглээ холдсон байна.



*Дархан Уул аймаг Шарын гол сум, Буянт олборлолтын газар
бичил уурхайчидтай уулзаж байгаа нь 2014 он*

2005 оны намар Түмэндэмбэрэл хань Л.Энхтүвшингийн олборлоод орхисон 2 шуудай чулууг авахаар тээврийн жолооч Н.Нэмэхбаяр ахын машинд дайгдан Сүжигт уул руу очжээ. Цас ороод шавар шалбааг ихтэй учир машинаар явах аргагүйд хүрч чулуугаа авч чадалгүй явган буцаж байтал нэг машин хажууд зогссон нь Тогтвортой бичил уурхай төслийн анхны менежер Д.Одончимэг болон төслийн багийнхан байлаа. Ийнхүү Швейцарийн хөгжлийн агентлагийн Тогтвортой бичил уурхай төслийн хамт олонтой уулзсан нь эгэл жирийн энэ бүсгүйн амьдралд хариуцлагатай бичил уурхайчин болох шинэ эхлэлийг тавьжээ.

2005 оны 10 сард Өмнөд Америкийн Болив, Перу улсад бичил уурхайн туршлагыг өөрийн нүдээр харснаар эх орондоо бичил уурхайчдыг албажуулах, тэдний амьжиргааны түвшинг дээшлүүлэх цаашлаад олон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг хариуцлагатай, зохион байгуулалттай

бичил уурхайчдыг бий болгоход өөрийн хувь нэмрээ оруулахаар шийдсэн байна. Түмэндэмбэрэл анх л сумын хэмжээнд хоргүй технологи ашиглан хүдэр боловсруулах цех байгуулахаар “Борнуур - мөнгөн усгүй амьдрал” нэртэй чуулга уулзалт зохион байгуулахад оролцсоноос эхлээд олон улсын бичил уурхайн 7-р бага хуралд төлөөлөгчөөр, 2010 онд “Эмэгтэйчүүдийн нүдээр” чуулганд бичил уурхайн сэдвээр илтгэл тавьж, түүнээс хойш олон удаагийн уулзалт, хурал, зөвлөгөөнд төлөөлөгчөөр оролцож байна.



Төв аймаг Борнуур сум Сүжигт олборлолтын газар 2010 он

2008 онд Швейцарийн хөгжлийн агентлагийн Тогтвортой бичил уурхай төсөл болон Засгийн Газрын дэмжлэгтэйгээр мөнгөн усгүй технологиор хүдэр боловсруулах туршилтын цех анх байгуулагдах үеэс нь гар бие оролцсон хүмүүсийн нэг нь Түмэндэмбэрэл юм. 2009 оноос Тогтвортой бичил уурхай төслийн орон нутаг дахь олон нийтийн идэвхжүүлэгчээр сонгогдон Борнуур сумын хэмжээнд хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийг зохион байгуулалтад оруулах ажилд бусдыгаа манлайлан ажилласан. Олон нийтийн идэвхжүүлэгчээр ажиллаж байх хугацаандаа Борнуур суманд байгуулагдсан бичил уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байсан “Бичил уурхайчдын холбоо” ТББ, нөхөрлөл, гишүүдийг чадавхжуулах, олборлолтын газрын зохион байгуулалт, орон нутгийн төр захиргааны байгууллагууд болон бусад хамтрагч талуудтай уулзах, Улаанбаатар хотноо зохион байгуулагдаж

байсан төрөл бүрийн сургалт, семинар, зөвлөгөөнд хувиараа ашигт малтмал олборлогчдыг хамрагдахад нь тусалж чиглүүлж байлаа. Улмаар 2010 онд “ХАМО” ХХК-д мөнгөн усгүй технологиор хүдэр боловсруулах цех-д ээлжийн ахлагчаар ажиллаж байгаад 2013 оны 4-р сараас Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо (МБУНДХ) байгуулах ажлын хэсгийн гишүүн, Холбооны удирдах зөвлөлийн гишүүнээр тус тус сонгогдож мөн оны 11-р сараас эхлэн тус холбооны нарийн бичгийн даргаар амжилттай ажиллаж байна.



Төв аймгийн Борнуур сум Хүдэр боловсруулах цехийн үйл ажиллагааг танилцуулж байгаа нь “Бичил уурхайчдын туршлага солилцох уулзалт” 2012 он

Бичил уурхайтай холбогдсон 15 жилийн хугацаанд тулгарч байсан олон бэрхшээлийг сум орон нутгийн удирдлагуудын дэмжлэг, “Бичил уурхайчдын холбоо” ТББ-ын гишүүд, Тогтвортой бичил уурхай төсөл, ХАМО ХХК, МБУНДХ-ны хамт олны дэмжлэг туслалцаатайгаар даван туулж иржээ.

Ихэнх бичил уурхайчдын хувьд алттай амьдралаа холбосноор хоёр идэхгүй, хоосон хонохгүй амьжиргаагаа залгуулдаг нь үнэний ортой бололтой. Түмэндэмбэрэлийн хувьд бичил уурхайгаар олсон орлого нэг дор бөөн орж ирээгүй, олсноо зөв зарцуулж хуримтлал үүсгэж байж л амьжиргаагаа дээшлүүлдэг гэдгийг тэрээр яриандаа дурьдаж байлаа.



*Жижиг төсөл сонгон шалгаруулах багийн гишүүнээр ажиллав.
2014 он*



*МБУНДХолбоо байгуулсан тухай хэвлэлийн
бага хурлын үеэр 2013 он*

Бичил уурхайчид удирдан зохион байгуулах ажилд оролцож байгаагийн хэрээр өөрийн мэдлэг чадвараа байнга дээшлүүлж суралцсаар байна. 2014 онд гэхэд л Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимийн даргын туслах, нарийн бичгийн ажилтны 4 сарын курс, Нийгэм эдийн засаг, хүний нөөцийн Соёмбо академийн

“Байгууллагын менежмент, манлайлагчдын өөрчлөлт” сэдэвт анхан ба ахисан түвшний сургалтуудад амжилттай суралцаж төгсчээ.

Өнөөдөр хариуцлагатай бичил уурхайчид хуулийн хүрээнд албан ёсны ажлын байртай болох, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг баримтлах техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх, гишүүдээ нийгмийн үйлчилгээнд хамрагдахад нь дэмжлэг үзүүлэх, чадавх бэхжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулахад Түмэндэмбэрэлийн оруулж байгаа хувь нэмэр их билээ.

Сэтгэл сайтай бүсгүйн ажил нь өөдрөг байж, бичил уурхайчдын эрх ашгийг хамгаалах их үйлст нь өндөр амжилт хүсье.

Алтан-Усныхан

*(Баянхонгор аймаг, Баян-Овоо сум,
“Алтан усны хөгжил” ТББ)*



Алтан усны хөгжил ТББ-ын хамт олон 2013 он

Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Уран хайрхан 2-р багийн Алтан ус хэмээх газар нэгэн цагт говь хангай хосолсон, мал сүрэг бэлчсэн гайхамшиг бүрэлдэн цогцолсон үзэсгэлэнт сайхан нутаг байлаа. Харин манай улс зах зээлийн харилцаанд шилжиж эдийн засгийн хүндрэл айл бүхэнд нүүрлэсэн тэр он жилүүдэд амин зуулгаа залгуулахын тулд ажилгүй, малгүй болсон иргэд энэ газарт олноор цугларч эмх замбараагүй алт олборлож эхэлсэн юм. Тэр үеэс олны хөлд талхлагдаж, унаган төрх алдагдаж, газар сайгүй овоолсон шороо, онгорхой нүхтэй үлдсэнд нь нутгийн зон олны сэтгэл эмзэглэх болсон билээ. Иймээс 2010 оны 2 сард газар нутгаа хамгаалах сэтгэлээр нутгийн хэсэг хүмүүс эвлэлдэн нэгдэж “Алтан ус-Аман ус” нэртэй төрийн бус байгууллага байгуулсан юм.

Тус ТББ-ын гишүүд олборлолт хийгдэж, орхигдсон талбайд хууль, журмын хүрээнд ажиллаж эхэлсэн билээ. Гэвч зарим нэг дураараа энд тэндгүй явж дуртай газраа алт олборлодог, үүрэг хариуцлагаа ухамсарладаггүй хэсэг хүмүүсийн хууль бус үйл ажиллагаанаас болж орон нутгийн удирдлагаас төдийлөн дэмжлэг авч чадаагүй юм. Үүний дараа бичил уурхайгаас амьдралаа

залгуулдаг 25 хувиараа ашигт малтмал олборлогч эвлэлдэн нэгдэж 2012 оны 4-р сарын 27-нд “Алтан усны хөгжил” нэртэй ТББ-ыг байгуулан ажиллаж эхэлсэн түүхтэй.



Нөхөн сэргээлт хийж байгаа нь 2014 он

ТББ-ын гишүүн бичил уурхайчид 2013 оны 6-р сарын 28-нд сум орон нутгийн удирдлагатай хамтран ажиллах гэрээ байгуулж Алтан усны олборлолт явагдаж, хөндөгдсөн газраас 2 га газарт өөрсдийн хүчээр техникийн нөхөн сэргээлт хийж, хашиж хамгаалан орон нутгийн засаг захиргаанд албан ёсоор хүлээлгэн өгснөөр тус байгууллагын үйл ажиллагаа эхэлсэн байна.

“Алтан усны хөгжил” ТББ унаган нутгийнхаа байгалийг хамгаалах, нөхөн сэргээх ажлаа үргэлжлүүлж хамгаалалтын бүс татан хамгаалж нөхөн сэргээлтээ чанаржуулж хийсэн байна.

Сумын ИТХ-аар “Алтан усны хөгжил” ТББ-ын хийсэн нөхөн сэргээлтийг хангалттай сайн гэж үнэлэн 2014 онд дахин 5 га газарт загвар нөхөн сэргээлт хийлгэх шийдвэр гаргасан нь ТББ-ын гишүүдийн урмыг сэргээж цаашид илүү эрч хүчтэй ажиллах урам зоригийг бадрааж зорилгоо зөв тодорхойлж амжилтанд хэрхэн хүрч болдгийн жишээ болгож чадсан билээ. Энэхүү ажлыг чанар сайтай гүйцэтгэх нь олон ажлын эхлэл төдийгүй бусдад үлгэр дууриал болохуйц томоохон ажлын нэг гэж хамт олноороо итгэл сэтгэлийн нэгэн зорилго дор ажиллаж байна. Ажлын амжилт хөдөлмөрийн

дотоод зохион байгуулалт сайн болохоор өдрөөс өдөрт өргөжин тэлж Аргалант, Уран байгаль 2 нөхөрлөлийн 25 гишүүнтэй, тэргүүн, ня-бо, нарийн бичгийн дарга, идэвхтэн байгаль хамгаалагч зэрэг 28 хүн ажиллаж байна. “Алтан усны хөгжил” ТББ-ын удирдлага, хяналтын зөвлөлөөс бичил уурхай эрхлэгчдийн хөдөлмөрийн аюулгүй байдалд анхаарч ажилд гарахын өмнө хүн бүрт аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч, гарын үсэг зуруулж хэвшсэний зэрэгцээ ажлын хантааз, маск, малгайгаа өмсч, гишүүнчлэлийн үнэмлэхээ биедээ авч ажилдаа гарч заншсан юм.



Судалгаанд хамрагдаж байгаа нь 2013 он

Бичил уурхайн үйл ажиллагаа албажиж, зохион байгуулалттай хэлбэрт шилжсэний нэг чухал үр дүн бол орон нутгийн засаг захиргаатай хамтран ажиллах гэрээ хэлцэл байгуулснаар бичил уурхайчид хөөгдөж туугдахгүйгээр ажиллаж, өөртөө итгэх итгэл нь нэмэгдэн, төрийн албан хаагчдын зүгээс хүндэтгэл хүлээх болсон. Байгууллагаас төрийн бодлого, Ашигт малтмалын тухай хууль болон бичил уурхайн хууль дүрмийн дагуу мэдээ судалгаа тогтмол гаргаж, жил, улиралд тайлангаа тогтоосон хугацаанд өгдөг нь ТББ-ын ажлын уялдаа холбоог улам бэхжүүлж хоёр тал харилцан мэдээллээр хангагдаж байна.

Орон нутгийн удирдлагууд, байгаль орчны улсын байцаагч нар сард хэд хэдэн удаа ирж зөвлөгөө өгч санал солилцон ажилладаг нь ажлын уялдаа холбоог сайжруулж ТББ-ын гишүүдийг улам

нягтруулж ажиллах урам зоригийг өгч байгааг тэмдэглэхэд таатай байна.

Одоо “Алтан усны хөгжил” ТББ нь загвар нөхөн сэргээлт хийж байгаа 5 га газартаа техникийн нөхөн сэргээлт болон биологийн нөхөн сэргээлт хийж дууссаны дараа өөр газар авч ажиллах саналаа сум орон нутгийн удирдлагад тавьжээ.

Долоо хоног бүрийн мягмар гарагт тогтмол нөхөн сэргээлт хийж хэвшиж байна. Нөхөн сэргээлтийн үйл ажиллагаанд бичил уурхайчид аль болох бүрэн бүрэлдэхүүнтэйгээр оролцдог. Нөхөн сэргээлт хийх өдөр ажлаа товлон хуваарилж, хоёр нөхөрлөл нөхөн сэргээлтэнд оролцсон уурхайчдын ирц бүрэлдэхүүн, оролцооны идэвх, хуваарьт газраа хийсэн ажлын хэмжээ, нөхөн сэргээлтийн ажлын чанар, ажлын хувцсаа нийтээрээ жигд өмсөж хэвшсэн байдал, аюулгүй ажиллагааны дүрэм мөрдөн ажиллаж байгаа байдал үзүүлэлтүүдээр уралдаантай ажилладаг. Эдгээр үзүүлэлтүүдийг харгалзан ням гараг буюу амралтын өдөр хоёр нөхөрлөлийн ажлыг дүгнэж түрүүлсэн нөхөрлөл, гоц сайн идэвхтэй ажилласан бичил уурхайчдыг шалгаруулан урамшуулдаг. Энэхүү урамшуулал нь хамт олныг төлөвшүүлэх, бичил уурхайчдад өөрөө өөртөө итгэх итгэлийг улам бадрааж байна.

“Алтан усны хөгжил” ТББ-ын бичил уурхайчид хүн амын орлогын албан татварт сар бүр нэг уурхайчин 14000 төгрөг, Бичил уурхайчдын Нэгдсэн Дээвэр холбооны татварт хүн бүр 1000 төгрөг, хамтын сангийн хуримтлалд хүн бүр 5000 төгрөг төлж хэвшсэн нь тэдний хувьд нийгмийн хариуцлагаа ухамсарлаж үүргээ биелүүлж байгаа нэр төрийн хэрэг бөгөөд хамтын сангийн хуримтлалаар хэзээ нэгэн цагт бие биедээ туслах боломж нээгдэнэ гэдэгт бүрэн итгэдэг билээ.

2014 оноос бүх гишүүд нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалд хамрагдсан бөгөөд ТББ-аас бичил уурхайчдыг 2 удаа эмнэлгийн үзлэгт хамруулан эмчилгээ оношлогоо хийлгэж, гишүүдийнхээ эрүүл мэндийн талаар онцгой анхаарч байна. Засаг даргатайгаа гэрээ байгуулж, тогтвортой ажлын байртай болсноор бичил уурхайчдын орлого нэмэгдэж, өрхийн амьжиргааны түвшин дээшилсэн байна. Тухайлбал, “Алтан усны хөгжил” ТББ-ын нийт

гишүүдийн 50 гаруй хувь нь гэр орон, хашаа байшингаа засч сайжруулж, 90 хувь нь машин, мотоцикл худалдан авч, 40 хувь нь ажлын тоног төхөөрөмж шинээр авч, 16 хувь нь хувийн жижиг дэлгүүр, цайны газартай болсон байна. Ийнхүү бичил уурхайчдын амьжиргаа дээшилж байгаа нь эргээд орон нутгийн хөгжилд эерэгээр нөлөөлөх нь дамжиггүй.

Тус ТББ нь Швейцарийн хөгжлийн агентлагийн Тогтвортой бичил уурхай төслөөс зарласан жижиг төслийн уралдаанд 3 дахь жилдээ оролцож 3 удаа шалгарч, эрүүл мэндийн, аюулгүй ажиллагааны, халамж үйлчилгээний, бизнесийн олон сургалтын төсөл авч хэрэгжүүлжээ. Эдгээр сургалтууд нь ТББ-ын гишүүдийг чадваржуулах, мэдлэг мэдээлэлтэй болгохоос гадна орон нутгийн тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах, нийгмийн хариуцлагатай гишүүдийг төлөвшүүлэх, тэдний хөгжлийг дэмжихэд орон нутгийн удирдлагуудтай үр дүнтэй хамтран ажиллах нөхцөл, боломжийг бүрдүүлэх замаар хариуцлагатай бичил уурхайг хөгжүүлэхэд ач холбогдолтой болсон байна.

2014 онд “Алтан усны хөгжил” ТББ нь Азийн сангийн нөхөн сэргээлтийн төсөлд анхны жилдээ хамрагдаж, орон нутгийнхаа эвдэрч сүйтгэгдсэн газрыг нөхөн сэргээж хэвийн ургацтай бэлчээрийн талбай болгоод зогсохгүй зарим боломжтой газрын хөрсийг эрүүлжүүлж газар тариалан эрхлэх нөхцлийг бүрдүүлэх зэрэг ажлуудыг хийхээр төлөвлөн ажиллаж байна.

Ажлын амжилт хамт олны итгэлцлээс эхэлдэг

*(“Хараа нутгийн ажилгүйчүүдийн холбоо” ТББ,
Сэлэнгэ аймаг, Баянгол сум)*

Бидний хэлж заншснаар Баруун Хараа буюу Сэлэнгэ аймгийн Баянгол сумын ажилгүй хэсэг иргэдийг Г.Цагаан, У.Мижиддорж, Н.Бүрнээбаатар нар зохион байгуулалтад оруулж “Хараа нутгийн ажилгүйчүүдийн холбоо” ТББ-ыг анх 1999 онд байгуулжээ. Энэ нь Баруун Хараад анхны зохион байгуулалттай бичил уурхайчид бий болох үндсийг тавьсан байна. Өнөөдөр 12 нөхөрлөл, 200 гаруй гишүүнтэй Бор толгойн Нарт гэдэг газар бичил уурхайгаар алт олборлож байна.




Баруун Хараагийн бичил уурхайчдын сайн туршилага олон улсын анхаарлыг татаж байна. 2014 он

2000 оны үед амьдрал хүнд хэцүү, ажил олдохгүй, хүмүүс мөнгөгүй, орлогогүй байлаа. Нутгийн иргэд мөнгө олж амьжиргаагаа залгуулах, үр хүүхдээ тэжээхийн тулд яахын аргагүй хувиараа алт олборлож эхэлсэн. Тухайн үед тэднийг нинжа хэмээн нэрлэж их адалдаг байв. Тэд жижиг уут, шуудай аваад машинд дайгдан 30 км яваад 5 км алхаж байж алттай газартаа хүрдэг байв. Анхандаа машин унаа байхгүй байсан ч аажимдаа унадаг дугуйгаар явдаг байснаа улмаар ЗИЛ-130 машинтай Баасанжав, Төмөр-Очир нарын жолоочийг хөлсөлдөг болжээ. Өвөл, зун ялгалгүй шороо ухаж, төрийн

албан хаагч, цагдаа нарт хөөгдөж, өнөөдрийн зохион байгуулалттай бичил уурхайчид болтлоо олон бэрхшээлийг туулжээ. Ерээд оны сүүл үеэс алт олборлож байсан хүмүүс мөнгөн ус хэрэглэж эхэлсэн байдаг. Хүмүүс гэр орондоо уур нүдүүр ашиглан хүдрээ нунтаглаж, мөнгөн устай хольж алтаа барьцалдуулж ууршуулдаг байжээ. Дараа нь хүчилтөрөгчийн баллоны дээд хэсгийг нь тайраад төмрөнд шарик гагнаад түүгээрээ нүддэг байв. Тэр нь явсаар саваачкан тээрэмтэй (алхан тээрэм) болж 2006 онд усан тээрмийг ашиглаж эхэлсэн байна.

Ийнхүү хувиараа ашигт малтмал олборлогчид бүртгэгдээгүй нөхөрлөлийн зохион байгуулалтад орж бие биенээ хүндэтгэн, аюулгүй ажиллагаандаа анхаарч, ажил амралтаа зохицуулах үүднээс ээлжээр ажилладаг болжээ.



Бор толгой олборлолтын газар 2010 он

Швейцарийн хөгжлийн агентлагийн Тогтвортой бичил уурхай төсөл хэрэгжсэний үр дүнд бичил уурхайчид хууль журмын дагуу үйл ажиллагаа явуулж, олон төрлийн сургалтанд хамрагдан мэдлэг мэдээллээ дээшлүүлж, орон нутгийн удирдлагатайгаа хамтарч ажиллах эхлэл тавигдсан. Гишүүд мөнгөн хуримтлал бий болгож, бие биенийхээ амьжиргаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор ээлж ээлжээр машин унаатай болж, амьдарч байгаа орон байраа сайжруулсаар ирлээ. Сайн зохион байгуулалттай эвсэг хамт олон байна гэдэг нь

итгэлцэл дээр тогтдог гэж олон гишүүд онцолж байлаа. Энд тэнд очиж газар ухаад байхгүй, нэг газраа тогтвор суурьшилтай ажиллах нь олон давуу талтайг харуулж байна. Тухайлбал, бичил уурхайчдын хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангах, өөр орон нутгаас хүмүүс ирж алт олборлох боломж хумигдах, орон нутгийн төр захиргааны байгууллагатай хамтын ажиллагаагаа бэхжүүлэх, бичил уурхайчдын орлого тогтмолжих, амьжиргаа дээшлэх зэрэг болно.

Бичил уурхайчдын нийгэм эдийн засаг, амьжиргааны судалгаанаас харахад “Хараа нутгийн ажилгүйчүүдийн холбоо” ТББ-ын гишүүдийн гуравны нэг нь бичил уурхай эрхэлж олсон орлогоороо өдөр тутмын хэрэгцээгээ хангаад илүү гарснаар нь хуримтлал үүсгэсэн байна. Бичил уурхайчдын 25 хувь нь мал худалдан авч бод малын тоогоороо тус ТББ тэргүүлж байна. Түүнчлэн зам дагасан хүнсний жижиг мухлагууд нь дэлгүүр, хоолны гэрүүд нь зоогийн газар болон өргөжиж байгаа нь бичил уурхай дагасан хөгжлийн нэг жишээ юм.

Баруун Хараа нутгийн алтны хишгийг хүртээгүй нутгийн иргэд бараг байхгүй. Зовлон жаргал ээлжилдэг хүний амьдралд бичил уурхайчид бие биеийгээ туслан дэмжихдээ алттай шороогоо харамгүй өгдөг нь Хараа нутгийнхны зан чанар юм.

“Бичил уурхайчид бид хүнд нөхцөлд алт олборлож орлого олдог. Өдөржин хүйтэн шороо чулуун дунд ажиллаж, гэрэлтүүлэг, агааржуулалт муутай нүхэнд мөлхөж, эрүүл мэндээрээ хохирон байж хоолны мөнгөтэй залгадаг улс. Уушиг, амьсгалын зам, бөөр нуруу, үе мөчний өвчтэй болдгийг мэдсээр байж амьжиргаагаа залгуулахаар энэ ажлыг хийж байна. Харин хамгийн гол нь зохион байгуулалтад орж, албажих нь чухал гэдгийг ойлгосон” гэж ТББ-ын гишүүд ярьж байлаа.



*Бор толгой олборлолтын газар
2011 он*

Бичил уурхайг хүлээн зөвшөөрч улс орны эдийн засгийн хөгжилд хувь

нэмрээ оруулсан албан ёсны хариуцлагатай салбар болоосой гэсэн чин хүслээ илэрхийлж байлаа. Тус ТББ нь орон нутгийн удирдлагууд болон сумын ИТХ-ын төлөөлөгчидтэй нягт хамтран ажилладаг.

Хараа голоороо овоглосон “Хараа нутгийн ажилгүйчүүдийн холбоо” ТББ-ын хамт олонд хариуцлагатай, зохион байгуулалттай бичил уурхайг хөгжүүлэх ажилд нь улам их амжилт хүсье.

Байгальд ээлтэй говийн бичил уурхайчид

(Дорноговь аймаг, Айраг сум, “Эх орон хамтын хүч” ТББ)



Дорноговь аймаг Айраг сум

Монгол хүн эх орныхоо газар нутгийг унаган төрхөөр нь хадгалах сэтгэлгээний илэрхийлэл болсон говь нутгийн ТББ бол “Эх орон хамтын хүч” юм. Анх 2010 оны 06-р сард иргэн Б.Жамбалсүрэн, Л.Лхагва тэргүүтэй 10 хүний санаачлага, нутгийн иргэдийн хүсэлтээр байгуулагдсан бөгөөд 2011 оны 3-р сараас эхлэн үйл ажиллагаагаа өргөжүүлж улмаар Швейцарийн хөгжлийн агентлагийн Тогтвортой бичил уурхай төсөлтэй хамтран ажиллаж байна. Тус ТББ удирдах зөвлөлийн 7 гишүүн, хяналтын зөвлөлийн 3 гишүүн, 25 нөхөрлөл, 1 хоршоо бүхий 125 гишүүнтэй.

ТББ-ын анхны санаачлагчид нь төрөлх нутаг Дорноговь аймгийн Айраг сумандаа жонш олборлогч албан бус бүлгүүдийг хуулийн хүрээнд зохион байгуулалтад оруулах, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хамруулах, орлогын албан татвараа төлж, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны стандартыг мөрдөж ажиллах, нөхөн сэргээлт хийх зэрэг үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлж байна. Бичил уурхайчдын мөрдөж ажиллах дүрэм, журмын заалтуудыг төрөл бүрийн сургалт семинар, ухуулга сурталчилгаа, ном, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан түгээдэг. 2010-2011 онд олборлолтын газруудад осол гараагүй.

“Эх орон хамтын хүч” ТББ нь Тогтвортой бичил уурхай төслийн дэмжлэгтэйгээр 10 бичил уурхайчныг Улаанбаатар хотноо Ражив Гандийн нэрэмжит «Үйлдвэрлэл урлалын сургууль»-д чулуугаар төрөл бүрийн гар урлалын зүйлс хийх сургалтанд хамруулснаар одоо тэдгээр хүмүүс Айраг сумандаа “Говь нутгийн чулуу” нэртэй хоршоо байгуулан ажиллаж байна. Одоо хоршоонд 2 хүн тогтмол ажлын байртай болсон. Байгалийн чулуугаар урласан бичиг хэрэглэлийн бүтээгдэхүүн нь Дорноговь аймгийн 2013 оны брэнд бүтээгдэхүүнээр шалгарчээ. Айраг сумын 90 жилийн ойг тохиолдуулан сумын төвдөө дурсгалын багана босгож орон нутгийнхаа бүтээн байгуулалтад хувь нэмрээ оруулсан байна.



“Бичил уурхайчдын туршилага солилцох уулзалт” 2014 он

Тэргүүн Л.Лхагва нь байгууллагынхаа албан хэрэг хөтлөлтийн стандартыг боловсруулан мөрдөж, нөхөрлөл бүрийг хувийн хэрэгтэй болгон, гишүүдийнхээ сайн сайхны төлөө зүтгэж яваа ажил хэрэгч эмэгтэй юм. Тэрээр аймгийн нэгдсэн эмнэлэгтэй хамтран гишүүдээ эрүүл мэндийн үзлэгт бүрэн хамруулах, чадавхжуулах төрөл бүрийн сургалтанд хамрагдан мэдлэг чадвараа дээшлүүлэхэд нь байнга анхаарч идэвх зүтгэлтэй ажилладаг.

ТББ байгуулснаас хойш бүх гишүүд нь эрүүл мэндийн даатгалд хамрагдсан бөгөөд нийгмийн даатгалд 92 бичил уурхайчин хамрагдаж 4.300.200 төгрөг, хүн амын орлогын албан татварт 71 бичил уурхайчин 4.830.000 төгрөгийг тус тус төлжээ.



Хоршооны бүтээгдэхүүнээс



Тэргүүн Л.Лхагва

Говийн хүмүүсийн ажилч хичээнгүй, хөдөлмөрч зан чанарыг энэ байгууллагын гишүүдийн газар нутгаа гэх сэтгэлээс нь харж болно. Үүний нэг жишээ нь олборлосон газартаа нөхөн сэргээлтийг амжилттай хийж, байгаль орчиндоо ээлтэй үйл ажиллагаа явуулж байна. 2012 онд анхны техникийн нөхөн сэргээлтээ “Баялаг жонш”, “Арвин баялаг” нөхөрлөлүүдийн хүчээр “Хайртын уурхай”-н орчимд гүн нь 11 м, өргөн нь 3 м, урт нь 12 м бүхий 4 газарт хийсэн ба орхигдсон уурхайд 800 м зам засаж мал услах нөхцлийг хангаж малчдын талархлыг хүлээнснээс гадна “Дэвжих”, “Ундрах”, “Галбын говь”, “Манажилт”, “Нутгийн тал” зэрэг нөхөрлөлүүд нь гар аргаар нөхөн сэргээлтийг гүнээрээ 20 м өргөн 1х1 хэмжээтэй 9 нүхийг булж шимт хөрсөөр хучилт хийсэн, 2013 онд “Талст”, “Андууд” нөхөрлөл Тагт гэдэг газар, 2013 онд “Баялаг жонш”, “Арвин баялаг” нөхөрлөлүүд Нүдэн багийн нутаг “Хайрт”-д техникийн нөхөн сэргээлтийг үлгэр жишээ гүйцэтгэлтэйгээр хүлээлгэж өгсөн туршлагатай.

2014 онд “Эх орон хамтын хүч” ТББ нь Азийн сангийн дэмжлэгтэйгээр зардал багатай нөхөн сэргээлтийг жоншны олборлосон талбайд анх удаа туршилтын журмаар амжилттай гүйцэтгэж байна.



Өмнө нь

Дараа нь

Ийнхүү “Эх орон хамтын хүч” ТББ нь нийт 2 газрын 12 га орчим жонш олборлосон талбайд биологийн болон техникийн нөхөн сэргээлт хийж цөлжилтийг бууруулах, газар нутгаа унаган төрхөнд нь оруулснаар хүн, мал амьтанд ээлтэй орчин бүрдүүлэх, экологийн тэнцвэрт байдлыг хадгалахад хувь нэмрээ оруулахаар өөрсдийн бүхий л хүч чадлаа дайчлан ажиллаж байна.

Биологийн нөхөн сэргээлт хийхэд овон товонг тэгшлэх, шимт хөрсөөр хучилт хийх, мод суулгах, үр цацах, хашаажуулалт хийх, усалгаа хийлгэх зэрэг ажлууд шаардлагатай тул хөдөлмөр зохион байгуулалтыг оновчтой хийж хамт олны хүчийг ашиглан байгалиа нөхөн сэргээж байна.

ТББ-ын гишүүдийн сарын дундаж орлого 500-600 мянган төгрөг болж хоол хүнс, өдөр тутмын хэрэгцээний зардлаас гадна өрхийн тогтвортой амьжиргааг бий болгоход чиглэсэн зардлын эзлэх хувь хэмжээ нэмэгдсэн байна. Тухайлбал, тэдний дөрөвний нэг нь суудлын болон ачааны машин, мотоциклтой болсон, 56 хувь нь нар, салхины цахилгаан үүсгүүр, цахилгаан мотор, хөргөгч, угаалгын машин, телевизор, DVD, CD, хөгжим зэрэг ахуй амьдралдаа хэрэгцээтэй эд хогшлыг худалдаж авснаас гадна 10 хувь нь бичил уурхайн орлогоосоо оюутан хүүхдийнхээ төлбөрийг төлж байна. Ийнхүү орлогын өсөлтийн гол шалтгаан нь хөөгдөж туугдахгүйгээр тайван нөхцөлд зохион байгуулалттайгаар жонш олборлож байгаа гэж үздэг байна.

Байгаль орчноо нөхөн сэргээх их үйлсэд хамт олноороо хүчин зүтгэж буй говийн бичил уурхайчдын төлөөлөл болсон та бүхэндээ ажлын өндөр амжилт хүсье.



Бичил уурхайчдын анхдугаар их хурал 2013 он

Бичил уурхайн хөгжил- сумын хөгжил

(Дундговь аймаг, Хулд сум, “Тахилгат лусын булаг” ТББ)

2008-2009 онд жил дараалсан зуднаар малчид малгүй болж Хулд суманд ажилгүйдэл, ядуурал нүүрлэсэн нутгийн иргэд бүгд банкинд цалин, малчны зээлтэй, дэлгүүрүүдэд өртэй хэцүү үе байлаа. Алслагдмал, дэд бүтцээс хол говийн сумын хувьд орлогын өөр эх үүсвэр байна гэдгийг төсөөлөөгүй байсан тэр үед “Түймэрт цагаан” гэдэг газар жонш илэрснээр бичил уурхайчдын зохион байгуулалтад орох эхлэл тавигджээ. 2011 оны 11 сарын 15-ны өдөр “Тахилгат лусын булаг” жонш олборлох бичил уурхайчдын ТББ байгуулагдаж одоо тэргүүнээр нь Ж.Рэнцэнпүрэв ажиллаж байна. Тус байгууллага нь нөхөрлөлийн гишүүдийнхээ эрх ашгийг хамгаалах, холбогдох хууль журмын хүрээнд төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах гол зорилготой. Одоо 19 нөхөрлөлийн 300 гишүүнтэй.



Бүх гишүүдийн хурал 2012 он

Хүмүүсийн итгэлийн гал жонш болж, Хулд суманд жонш гарангуут хууль бусаар олборлоод эхэлсэн тэр мөчид сум, орон нутгийн удирдлагууд Засгийн газрын 72 дугаар тогтоолын дагуу сумын ИТХ-ыг хуралдуулж хэд хэдэн тогтоолуудыг гаргасан байдаг. Сумын удирдлагууд 2010 оны 11 сард 50 га газрыг бичил уурхайн зориулалтаар олборлох талбайн дүгнэлтийг АМГ-аас гаргуулсан.

Хулд сумын нутгийн иргэд нинжагийн хүнд замаар яваагүй, анхнаасаа л холбогдох хууль журмын дагуу бичил уурхайгаар ажиллаж эхэлсэн.

“Тахилгат лусын булаг” ТББ-ын бичил уурхайчид АМГ-ын дүгнэлт гарснаас хойш жигдхэн ажиллаж өдийг хүрч байна. Зун намартаа хэсэгхэн хугацаанд хаагддаг аж. Хавар, цагаан сарын дараа хэсэг ажиллуулаад 3 сарын 20-ноос 5 сар хүртэл хөрс гулгалтын үед нэг сар хаагддаг. Энэ үед газар гэсч нурулт үүсэх аюултай байдаг.



Түймэрт цагаан олборлолтын газар 2012 он

Хулд сум 2200 гаруйхан хүнтэй болсон байсан үе, одоо хүн ам маш их нэмэгдэж байна. Арав, хорин жилийн өмнө нүүгээд явсан хүмүүс буцаж ирж байна. Сумын Засаг даргын баримталж байгаа бодлого бол хүмүүс нутагтаа буцаад ирвэл нөхөрлөл байгуулж сумын удирдлагатай гэрээгээ байгуулаад бичил уурхайгаар ажиллаж болно гэж үздэг.

Харин одоо ард түмний амьдрал дээшилж, бичил уурхайчдын дотор зээлтэй хүн нэг ч байхгүй, харин ч банкинд тодорхой хэмжээний хуримтлалтай болцгоосон.

Орон нутгийн эдийн засагт бичил уурхайн үйл ажиллагаанаас оруулж байгаа хувь нэмрийг Хулд сумын хувьд бусад бичил уурхай бүхий сумдтай харьцуулахад хамаагүй их юм.

Бичил уурхайгаар ажиллаж, амьдрал ахуй нь дээшилж дэлгүүртэй болсон, сумын төвд хувийн байшин гурав дөрөвхөн л байдаг байсан бол одоо бараг л хашаа болгон байшинтай болсон байна. Сумын ихэнх хүмүүс унаа машинтай болжээ. Хулд суманд анх бичил уурхай ажиллаж эхлээд 2 сар болоход хятад мотоцикл 2 өдрийн дотор 180 ширхэг зарагдсан ба тухайн үед 1 мотоцикл нэг сая хоёр зуун тавин мянган төгрөгний үнэтэй байсан.

Бичил уурхайчдын олборлосон жоншийг хоёр компани гэрээгээр өдөрт нь худалдан авдаг. Зарим бичил уурхайчдын хувьд өдөр бүр ажилладаггүй.

Тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа үед бичил уурхайчдын өдрийн дундаж орлого 50-200 мянган төгрөг, сарын дундаж орлого 2 сая төгрөг байдаг.

Ж.Рэнцэнпүрэвийн хэлснээр хөдөлмөр хамгааллын зааварчилгаа өгөх мэргэжлийн хүн ТББ-д байхгүй учраас 2012, 2013 онуудад Швейцарийн хөгжлийн агентлагийн Тогтвортой бичил уурхай төсөлтэй холбогдож хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, хууль эрх зүйн талаар болон жижиг бизнес эрхлэх, байгууллагын менежмент, манлайлал зэрэг олон сургалтад хамрагдаж их зүйл сурсан. Энэ нь байгууллагаа удирдахад тус нэмэр болж байна. ТББ маань гишүүдийнхээ хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаанд анхаарч хамгаалалтын малгай, ажлын хувцас олгосноор ажлаа эхэлж байжээ.

Хамгийн гол нь бид бие биенээ сайн мэддэг нэг нутгийнхан учраас зохион байгуулалтад орж, хамт олон болж ажиллахад амар байдаг. Сумын ИТХ-ын төлөөлөгчөөр бичил уурхайчдын төлөөлөл болсон 6 хүн сонгогдсон.



Суурьшлын бүс тогтоож эмх цэгцтэй болсон нь 2013 он

Тус ТББ сум орон нутагтайгаа нягт хамтран ажилладаг ба одоогоор улсад 3 тэрбум төгрөг татварт төлж, нөхөн сэргээлтийн сандаа 94 сая төгрөгийг хуримтлуулснаас сумын төвдөө 24 сая төгрөгөөр нь цэцэрлэгт хүрээлэн байгуулсан.



*Дүйцүүлэх нөхөн сэргээлтээр 2 га талбайд
2000 мод тарив. 2013 он*

Бичил уурхайчдаас худалдан авч байгаа жоншны нэг тонн бүрээс нь 5000 төгрөгийг сумандаа төвлөрүүлж сум хөгжүүлэх санд 3000 төгрөг, нөхөн сэргээлтийн санд 2000 төгрөгийг тус тус оруулдаг. ТББ дүйцүүлэх нөхөн сэргээлт хийж, сумын төвөөс холгүй 2000 мод тарьж, хашаажуулан арчилж байна.

Өнөөдөр ихэнх гишүүдийн хүүхдүүд их дээд сургуульд, заримынх нь гадаадад суралцаж байна. Бичил уурхайчид төдийгүй сум орон нутгийн төрийн байгууллагынхан амралтын өдрүүдээр жонш олборлож амьдрал ахуйдаа нэмэрлэж байна.

Бичил уурхайчдын дунд уушиг ходоодны өвчлөл нэлээд байгаа бөгөөд эрүүл мэндийн мэдлэг мэдээллээ нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага тулгарсан юм. “Тахилгат лусын булаг” ТББ Тогтвортой бичил уурхай төслийн жижиг тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдан гишүүддээ эрүүл амьдралын хэв маяг, зөв хооллолт, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх эрүүл мэндийн жижиг төслийг мэргэжлийн эмч нартай хамтран хэрэгжүүлж байна.



*Тус сумын шинэ дээвэртэй байшингууд нь бичил уурхайчдын
орлогоор баригдсан. 2014 он*

Сум орон нутгийнхаа эдийн засгийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулж, амьжиргаагаа дээшлүүлж байгаа Тахилгат лусын булаг ТББ-ын хамт олондоо улс орныхоо хөгжил цэцэглэлтэд зориулж улам ихийг хийж бүтээхийг хүсье.

Цагаан цахирынхан

(Баянхонгор аймаг, Баян-Овоо сум, “Хувиараа ашигт малтмал олборлогчдыг дэмжих холбоо” ТББ)

“Хувиараа ашигт малтмал олборлогчдыг дэмжих холбоо” (ХАМО ДХ) ТББ-ын хамт олны түүхийг сөхвөл төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн нийгэмд шилжих үед улсын үйлдвэр, аж ахуйн нэгжүүд татан буугдаж олон хүн ажилгүй болж, 1999, 2000, 2002 оны дараалсан ган зуднаар малчид малаа алдсан, бусад аймаг орон нутгаас ирсэн иргэд 2006 оноос Цагаан цахирын орхигдсон газар дээр цугларч олборлолт явуулж эхэлсэн зэргээс үүдэлтэй. Тухайн үед алт олборлогчид зохион байгуулалтад ороогүй, гадны өөр аймаг сумдын иргэд ихээр цугларч эмх замбараагүй байдал бий болгож “нинжа” хэмээх нэрээр хувь хүмүүс үйл ажиллагаа явуулж байлаа. 2008 онд Засгийн газрын 72 дугаар түр журам гарч Л.Бямбадорж тэргүүтэй нутгийн иргэд 10 бригад болж олборлолт явуулснаар үндсэн ордын бичил уурхайчид зохион байгуулалтад орох эхлэл тавигджээ.



ТББ-ын хамт олон 2013 он

2009 онд Цагаан цахирт олборлолт явуулж буй хувиараа ашигт малтмал олборлогч нутгийн иргэд анхны хурлыг хийж тэргүүнээр Л.Бямбадоржийг сонгож ТББ байгуулсан. Улмаар 2010 онд Засгийн газрын 308 дугаар тогтоолоор бичил уурхайгаар ашигт малтмал

олборлох журам батлагдаж ТББ үйл ажиллагаа өргөжин тэлж 30-аад цооног дээр 400-600 гаруй иргэд ажиллаж эхэлсэн.



Цагаан цахир дахь суурьшлын бүс 2014 он

Ингээд үндсэн ордоос ашигт малтмал олборлож эхэлсэн ХАМО иргэдийн хүдрийг баяжуулах шаардлага гарч бигүм тээрэм ашиглаж эхэлсэн бөгөөд 2007 онд Хонгор суманд үүссэн нөхцөл байдлаас болж тээрмүүдийг хураахад тус аймгаас нийт 34 тээрэм хураагдсан тоо байдаг. Үүнээс шалтгаалан нэг газар төвлөрөн явагдаж байсан алтны хүдэр баяжуулах үйл ажиллагаа далд хэлбэрт шилжиж айл өрхүүд мөнгөн ус ашиглан алт бариулж химийн хорт бодисын аюулыг улам нэмэгдүүлж өөрсдийгөө ч, өрөөлийг ч хордуулах болсон. Харин 2008 онд Засгийн газрын 28 дугаар тогтоол гарч химийн хорт бодис хэрэглэхгүйгээр хүдэр баяжуулах цех байгуулах шийдвэр гарсан нь иргэдийн үндсэн орд дээр ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлсэн байна.

Эдгээр боломжуудыг орон нутгийнхаа иргэдэд олгох, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангасан нэгдсэн зохион байгуулалтад орсон бичил уурхайг бий болгох зорилгоор “ХАМО ДХ” ТББ гишүүдийнхээ төлөө ажиллаж эхэлжээ.

Өдгөө “ХАМО ДХ” ТББ нь удирдах зөвлөлийн 9, хяналтын зөвлөлийн 3 гишүүн, нарийн бичгийн даргагэсэн бүрэлдэхүүнтэйгээр 55 нөхөрлөлийн 450 орчим гишүүдийн эрх ашгийг хамгаалан ажиллаж байна.



Цагаан цахирынхан 2011 он

“ХАМО ДХ” ТББ анх 2011 онд орон нутагтайгаа 2 талт гэрээ байгуулан ажиллаж байх үедээ нөхөрлөлийн гишүүн бүр сар болгон 21,000 төгрөг орон нутагт төлдөг байсан бол 2012 оны 11 сард 3 талт гэрээ байгуулж ажилласнаар нөхөрлөл болгон сар бүр 250,000 төгрөгийг хүн амын орлогын албан татварт, 2013 онд сумын татварт 67 сая төгрөг төлж, 2014 онд 100 сая төгрөг төвлөрүүлэхээр ажиллаж байгаа аж. Мөн эрүүл мэндийн даатгалд нийт гишүүдийнхээ 80 гаруй хувь, нийгмийн даатгалд 50 гаруй хувийг хамруулахаар зорьж орон нутаг, төрийн байгуулагуудтай хамтран ажиллаж байна.



Цагаан цахир олборлолтын талбай 2014 он



Гишүүдийн хурал 2014 он

“Гэрээ байгуулаад ажиллахаар их тайван, осол авааргүй ажилладаг. Харин гэрээ байгуулаагүй үед хөөгдөж туугдаад нууцаар шөнө орой ажиллан хүмүүс осол аваарт өртөх нь их байсан” хэмээн тэргүүн Ч.Отгонбаатар ярьж байна.

Цагаан цахир дахь бичил уурхай эрхэлж байгаа энэ хэсэг газар “Спейшл майнз” ХХК-ийн мэдлийнх. Спейшл майнз ХХК-ийн олборлолт явуулах эрхтэй 1052 га газрынх нь 30 га-д нь 3 талт гэрээ байгуулж олборлолт явуулах зөвшөөрлийг ТББ-ын гишүүдэд өгснөөр тогтвортой ажлын байр бий болгон үйл ажиллагаа явуулж байгаа ажээ.



Гурван талт гэрээ байгуулж байгаа нь. 2014 он

“ХАМО ДХ” ТББ байгуулагдсанаар гишүүддээ хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны анхан шатны мэдээлэл өгч эхэлсэн бөгөөд олборлолт хийж байгаа цооногийнхоо аюулгүй ажиллагааг бүрэн хангаж ажиллаж байна.



Цооногийн дотор тал /өмнө нь/



Цооногийн дотор тал /дараа нь/

“ХАМО ДХ” ТББ-ын гишүүд Шударга олборлолтын стандартын системд нэгдэж орох зорилго тавин хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар олон талт үйл ажиллагааг Швейцарийн хөгжлийн агентлагийн Тогтвортой бичил уурхай төсөлтэй хамтран явуулж байна.

Тэд 55 нөхөрлөлийн нүхний амыг зөвлөх инженерийн тусламжтайгаар аюулгүй байх үүднээс засаж, татлага тайлыг стандартын тороостой болгож, түгжээтэй тайлыг нүх болгон дээр хийсэн нь хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаанд сайнаар нөлөөлж осол аваараас урьдчилан сэргийлж байна.

Ийнхүү зохион байгуулалтад орж албажсан бичил уурхайчид орон нутагтаа аймаг сумынхаа ажилгүйдлийг бууруулах, орон нутгийн эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ оруулах зорилго тавин ажиллаж байна. “ХАМО ДХ” ТББ-ын гишүүдийн бараг 80 хувь нь суудлын болон ачааны машин, мотоциклтой болсноос гадна гурван бичил уурхайчны нэг нь оюутан хүүхдүүдийнхээ сургалтын төлбөрийг саадгүй төлж байгаадаа сэтгэл хангалуун байгаа аж. Мөн бичил уурхайчдын 20 гаруй хувь нь банк болон хувь хүнд тавьсан өр зээлээ төлж дуусгасан байна.

Зохион байгуулалтаараа тэргүүлэгч байгууллага

(Дархан-Уул аймаг, Шарын гол сум,

Буянтын хөндий-Шарын гол ТББ)

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын нутагт үйл ажиллагаа явуулдаг “Буянтын хөндий-Шарын гол” ТББ нь 2009 онд хувиараа алт олборлогчид өөрсдийн төрөлх нутагтаа зохион байгуулалтад орсноор албан ёсоор олборлолт явуулахын зэрэгцээ нөхөн сэргээлтийг хийж, шинэ арга хэлбэрээр ажиллаж байна. Олборлолтын газар нь бичил уурхайчдад хишиг буянаа хайрласан, сүүлийн 5-6 жил тогтвортой үйл ажиллагаа явуулж амьжиргаагаа залгуулж буй “Буянтын хөндий” хэмээх шороон орд бөгөөд сумын төвөөс арваад километрийн зайд оршдог.



“Буянтын хөндий Шарын гол” ТББ-ын үйл ажиллагаа жигдрэхийн хэрээр гишүүнээр элсэх бичил уурхайчдын тоо нэмэгдэж өнөөдрийн байдлаар 64 нөхөрлөлийн 350 гаруй гишүүдтэй болжээ. Зохион байгуулалтын хувьд удирдах зөвлөл 9, хяналтын зөвлөл 5, аврах алба 5 гишүүнтэй ажиллаж байна. Анх “Буянтын хөндий Шарын гол” ТББ-ыг Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбооны гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан О.Цэцэгмаа санаачлан байгуулсан юм. Одоо ТББ-ын гүйцэтгэх захирлаар Ч.Цэнгэлмаа гэж хөдөлмөрч, хичээнгүй, шударга бүсгүй ажиллаж байна. Олон манлайлагч бүсгүйчүүд удирдан

зохион байгуулах, чиглүүлэх, бусдыгаа уриалж чаддаг нь энэ байгууллагын нэг онцлог юм. Байгууллагын удирдах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо давамгайлдаг нь бичиг баримт бүрдүүлэлт, хөтлөлтийн эмх цэгцтэй байдал, цэвэр цэмцгэр орчноос шууд харагдана.



“Буянт” олборлолтын талбай 2013 он

Шарын голын бичил уурхайчид өнөөдөр аль ч байгууллагаас дутахааргүй зохион байгуулалтад орж ажиллаж байгаадаа сэтгэл хангалуун байна. Өмнө нь олборлолтын газар архи уух, хогоо ил задгай хаях, ариун цэврийн байгууламж хаана байгаа нь мэдэгддэггүй замбараагүй байсан бол одоо бүх зүйл цэгцтэй болжээ.

2013 оны 10 сараас ТББ-даа шинэчилсэн бүртгэл хийж бүх гишүүдээ үнэмлэхжүүлэх ажлыг санаачлан хэрэгжүүлсэн. Сайн зүйлд садаа мундахгүй гэгчээр олборлолтын газраасаа хөөгдөж туугдах, албадлагаар тарах, заримдаа том компани болон сум, аймгийн удирдлагын түвшинд үл ойлголцох олон бэрхшээлтэй тулгарч байлаа.

Тогтвортой бичил уурхай төслөөс өгсөн гэрийг оффисийн зориулалтаар ашиглан ТББ-ын танилцуулга, өдөр тутмын ажлын мэдээлэл, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм журмыг тайлбарласан самбар ажиллуулан гишүүддээ байнга сурталчлан таниулж байдаг. Мөн гишүүддээ зориулсан хоолны гэрийг ээлжээр

ажиллуулж амт чанартай, халуун хоолоор үйлчилж байгаа нь хүнд хөдөлмөр эрхэлдэг бичил уурхайчдынхаа эрүүл мэндийг анхаарч байгаагийн илрэл юм.

Шарын гол сум 8000 гаруй хүн амтай. Шарын голын уурхай, төсвийн хэдэн байгууллагаас өөр ажлын байр байхгүй. Хөдөлмөрийн насныхны дийлэнх нь ажилгүй залуус байдаг. Шарын голд бичил уурхайтай холбогдоогүй өрх гэр бүл гэж байхгүй. Зөвхөн гэр бүлээ төдийгүй төр, хувийн хэвшлийнхнийг ч тэжээж байна гэхэд хилсдэхгүй. Бичил уурхайчид ажиллаад эхлэхэд шатахуун түгээх станцаас эхлээд дэлгүүр, такси гээд үйлчилгээнийхэн илт хөл хөдөлгөөнд орчихно. Дэлгүүрийн барааны гүйлгээ сайжирч амьдрал өрнөдөг. Бичил уурхайчдын ажил зогсвол гудамжинд хүн харагдахгүй болно.



*Амжилтанд хүрсэн компаний туршилагаас
судалж байх үеэр 2014 он*

Бичил уурхайчид өмнө ажиллаж байсан 2,8 га газарт тухайн үеийн сумын Засаг даргаас зөвшөөрөл авч албан ёсоор ашиглалт явуулж дуусаад дундын сангаасаа 3.200.000 төгрөг, мөн Тогтвортой бичил уурхай төслийн жижиг тэтгэлэгт хөтөлбөрөөс 5.000.000 төгрөгийг зарцуулж нөхөн сэргээлт хийж хүлээлгэн өгсөн. Харин одоогийн олборлолт хийж байгаа газартаа сумын удирдлагуудтай хэлэлцэж зөвшилцсөний дагуу ажиллаж байна.

“Буянтын хөндий Шарын гол” ТББ нь нийгмийн хариуцлагаа ухамсарлан гишүүдийнхээ нийгмийн асуудалд анхаарахаас гадна орон нутгийн хөгжилд чиглэсэн үйл ажиллагаануудад идэвхтэй оролцож байгаа шилдэг хамт олон болжээ. Нөхөрлөл бүрээс сар болгон 40 мянган төгрөгийн татвар хурааж, 10 мянган төгрөгийг “Нөхөн сэргээлтийн сан”-даа, 30 мянган төгрөгийг дундын сандаа хуримтлуулан үйл ажиллагаандаа зарцуулж хэвшжээ. Одоогийн байдлаар 3.122.000 /гурван сая нэг зуун хорин хоёр мянга/ төгрөгийг сум, орон нутгийнхаа хөгжилд хандивлажээ. Тухайлбал, сумын 50 жилийн ойн арга хэмжээг тохиолдуулан соёлын төвийг шинэчлэн засварлах, цэцэрлэгийн ахлах ангид анги тохижуулахад нь зориулж мөнгөн хандив тусламж өгч хүүхэд залуучуудын сурч боловсрох ая тухтай амьдралын орчинг бий болгоход илүү ихээр анхааран ажиллаж байна. 2013 онд сумын “Хүүхдэд ээлтэй байгууллага”-аар шалгарсан байна. Мөн 2-р сургуулийн 11-р ангиудын дунд урлаг спортын болон зохион бичлэгийн уралдаануудыг уламжлал болгон зохион байгуулж ТББ-ынхаа нэрэмжит шагнал урамшууллыг гардуулсан.

Байгаль орчиндоо ээлтэй байгууллага болох зорилгоор нөхөн сэргээлтийн үйл ажиллагааг тогтмолжуулж, олборлолтын талбай болон голын голдрил орчмыг цэвэрлэж байгалиа хамгаалахад тустай үйл ажиллагааг санаачлан хэрэгжүүлсээр байна. Буянтын хөндий Шарын голынхон хуулиа дээдэлж ажиллах, хамт олны дунд сайхан уур амьсгалыг бүрдүүлэхэд ТББ, нөхөрлөлийн удирдлагуудын манлайлал чухал үүрэг гүйцэтгэж байна.

ТББ-ын гишүүдийнхээ ар гэр, ахуй амьдралд нь ойрхон байх үүднээс тэдэнд тохиолдож буй баяр жаргал, зовлон гунигийг байнга хуваалцаж, нэг нэгийгээ дэмжин тусалж ажилладаг эвсэг хамт олон.

Зохион байгуулалтаараа тэргүүлэгч Буянтын хөндий Шарын гол ТББ-ынханд тогтвортой, хариуцлагатай бичил уурхайг хөгжүүлэх их үйлсэд нь өндөр амжилт хүсье.